

**Зөв бичих дүрэм
шинжилэх ухааны үндэстэй байх ёстой**

Домийн ТӨМӨРТОГОО*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Хэл шинжлэлийн салбар

Received: 08 September 2025 / **Accepted:** 20 September 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Монголчууд бид XX зууны дунд үеэс кирил үсэгийг зээлдэн авч, уламаар түүний зөв бичих дүрэмийг боловсруулан хэрэглэсээр наяд гаруй жил болж байна. Тэр цагаас кирил бичиг нь Монгол Улс дахь төрийн албан ёсны бичиг болж, бүх нийтээр бичигтэн болж, бүх шатны сургалт, төр, захиргааны байгуулга, хэвлэл мэдээлэл, урлаг соёлын бүх ажиллагаа гагцхүү кирил бичигээр явагдсаар ирсэн билээ. Хэдий тийм боловч кирил бичигийн зөв бичих дүрэмд эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог өрөөсхөл тусхасан зүйл бий бөгөөд түүнийг хэл шинжлэлийн үндэслэлтэйгээр засаж сайжруулах шаардлагатай байгаа билээ. Би энэ үгүүлэлдээ кирил бичигийн зөв бичих дүрэмийг хэлнийхээ бүтэцэд ойртуулан засаж сайжруулах арга замын талаар үгүүлсэн болно.

Түлхүүр үг: кирил бичиг, зөв бичих дүрэм, сайжруулах шаардлага, хэл шинжлэлийн үндэслэл

**Reconsidering Mongolian Cyrillic Orthography
on a Theoretical Basis**

TUMURTOGOO Domii

Department of Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: Since the mid-20th century, we, the Mongolians, have adapted the Cyrillic script and developed its orthographic standards for over a century. During this period, Cyrillic has been established as the official script of Mongolia, widely used in all levels of education, government institutions, media, and cultural activities, and so on. Despite its widespread use, the current Cyrillic orthography does inadequately reflect the structure and system of the Mongolian language. Therefore, it is imperative to revise and enhance this orthography in accordance with linguistic principles and this paper focuses on methods for the enhancement of the Cyrillic orthography aligning with the Mongolian language structure.

* © Д. Төмөртоого, 2025, Email: dtumurtogoo@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

1. Удирдхал

Одоогоос жаран жилийн өмөнө академич Бимбын Ринчен яг ийм нэртэй нэгэн үгүүлэл нийтлүүлжээ. Тэрхүү үгүүлэлд дэвшүүлсэн санааг товчоор нэгэдхэн тоймловол: *‘аливаа үсэг бичигийг авч хэрэглэхдээ эхлээд ‘үсэг зүй’-н асуудалыг бодьтойгоор шийдээд, дараа нь ‘зөв бичих зүй’-гээ боловсруулдаг зарчимтай. Гэтэл манайд кирил бичигийг авч хэрэглэхийн тул эхлээд хэлнийхээ үндэсэн авиалбарын бүрэлдэхүүнийг тогтоож, уламаар түүндээ тохирсон үсэгийг сонгон авч чадаагүйгээс зөв бичих дүрэмдээ үгийн бүтэц, хэл зүйн хэлбэрийг зөв тусхаж чадсангүй’* (Ринчен, 1964.7.2) гэсэн санааг илэрхийлжээ. Бүтэн жараны өмөнө нийтлүүлсэн тус үгүүлэлд дэвшүүлсэн асуудал, шүүмжит санаанууд нь эдүгээ хүртэл огт хөндөгдөөгүй, хэвээрээ байгаа тул би энэ үгүүлэлээ тэрхүү үгүүлэлийн нэрээр давтан нэрлэхээр шийдлээ.

Миний бие энэ үгүүлэлдээ кирил бичигийн ач холбогдолыг үгүйсгэх, кирил үсэгийн зөв бичих дүрэмийн үндэсийг боловсруулагчидыг буруушаан шүүмжилэх зорилт огт тавиагүй, харин одоогийн зөв бичих дүрэмд эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог гажуудуулсан ямар өрөөсхөл талууд байгаа хийгээд тэдгээрийг засаж сайжируулах ямар арга зам байгаа талаар санал бодолоо илэрхийлж, уламаар цаашид тогтвортой, тодорхой, сурахад хилбар, сургахад дөхөмтэй, товч үсэгийн дүрэм боловсруулах боломжийн талаар үгүүлэхийг зорьсон болно.

Жич: Би энэхүү үгүүлэлийнхээ утга санааг уншигч олонд илүү ойлгомжтой, тодорхой болгохын үүднээс кирил бичигийн зөв бичих зүйн тулгамдсан асуудалуудыг хэд хэдэн дэд сэдэвт хувааж, тайлбарлан таниулахыг хичээсэн болно.

2. Судалгааны арга зүй

Орос кирил үсэгийг монгол хэлэнд тохируулан авч хэрэглэх талаар 1941, 1945 оны тогтоол, кирил үсэгийн зөв бичих дүрэмийн талаар хэлэлцсэн 1957 оны олон улсын эрдэм шинжилгээний хуралын материал, кирил бичигийн зөв бичих дүрэмийн толь боловсруулах тухай 2003, 2013, 2018 оны тогтоол шийдвэр, буриад, халимагчуудын авч хэрэглэсэн кирил бичигийн дүрэмийн талаархи эрдэмтэдийн судалгааны бүтээлүүд зэрэгийг голлон ашигласан болно.

Орчин цагийн монгол хэлний авианы бүтэц, тогтолцоо болон кирил үсэгийн зөв бичих дүрэмийг авиа зүйн үүднээс харьцуулан авч үзсэн болно.

3. Кирил бичиг, түүний гарал, хөгжил

3.1. Кирил үсэгийн гарал. Эртний Византийн загалмайн шашины ахан дүү Кирил [Kýrillos] (827-869), Мифодий [Methódios] (815-885) хоёр IX зууны дундуур (863 он) эзэн хааныхаа зарлигаар эртний грек үсэгийн дүрсэд тулгуурлан слав үндэстэний хэл аялгууг тэмдэглэхэд зориулсан шинэ үсэгийг зохиосон нь эдүгээ хүртэл зохиогчийнхоо нэрээр *“кирил үсэг”* хэмээн нэрлэгдсээр иржээ. Анхандаа зөвхөн загалмайн шашинтаны сүм хийдийн хүрээнд хэрэглэгдэж байсан кирил бичигийн хэрэглээ нь Болгараас хальж, Серби, Хорват, Орос, Украин, Беларус зэрэг бусад слав хэлтэнүүдийн дунд дэлгэрсээр эдүгээ Европын Холбооны хэмжээнд латин үсэгийн дараа орох хоёрдох албан ёсны бичиг болтолоо өргөжиж, үсэг тэмдэгт нь олоноор нэмэгдсэн байна. Анхандаа 18-хан үсэгтэй байсан кирил бичигийг слав хэлтэнүүд өөр өөрийн хэл аялгуундаа тохируулан шинэ шинэ үсэг нэмсээр эдүгээ 74 үсэгтэй болгожээ.

3.2. Орос кирил үсэг. Болгараас гаралтай кирил бичиг Х зууны сүүлчээс доронод слав хэлтэн болох Киевийн оросуудын дунд дэлгэрч, уламаар түүнийг хэл аялгууныхаа онцлог шинжид тохируулан нэмэж зассаар нэгдүгээр Петр хааны шинэчилэл (1710 он)-ийн үед 33 үсэг бүхий бүх нийтийн үсэг бичиг болгон баталгаажуулжээ. Хожим XVIII-XIX зууны үед орос кирил үсэгийн бүрэлдэхүүнд нийлмэл авиа тэмдэглэсэн хэд хэдэн шинэ үсэг нэмсэн боловч 1917-1918 оны шинэчилэлээр хожим нэмсэн үсэгүүдийг хасаж, дахиад 33 үсэгтэй болгосон нь одоо хүртэл хэвээрээ хэрэглэгдэж байна.

3.3. Кирил үсэгийн дэлгэрэл. XX зууны эхэн үеэс Зөвлөлт Холбоот Уласын бүрэлдэхүүнд багтах болсон Башкир, Казах, Киргиз, Түркмен, Тува, Үзбек, Якут зэрэг түрэг хэлтэн, Нанай, Негидаль, Эвенки, Ороки зэрэг манж-түнгүүс хэлтэнүүд болон Буриад, Халимаг зэрэг монгол хэлтэнүүдэд кирил үсэгийг бараг нэгэн зэрэг хэрэглүүлэх болжээ. Ингэснээр слав үндэстэнүүдийн дунд анх дэлгэрсэн кирил бичиг нь слав хэлтэнүүдээс гадна Ази тивийн слав бус олон үндэстэний үсэг бичиг болж, дотороо слав болон слав бус үндэстэний гэсэн хоёр өөр салбар болон хэрэглээний цар хүрээ нь үлэмжхэн тэлжээ. Түрэг, Түнгүүс, Монгол үндэстэнүүд кирил үсэгийг өөр өөрийн хэл аялгууны авианы бүрэлдэхүүнд тохируулан тус бүрдээ 35-45 үсэгтэй болгожээ. Тийнхүү олон үндэстэний дундын бичиг болсон кирил үсэгийн бүрэлдэхүүн нь нэмэгдсээр, эдүгээ слав болон слав бус хэлтэнүүдийн дунд 130 гаруй үсэг бүхий компьютерийн өргөдхөсөн платформтой болоод байна. Таширамд дурдахад, үзбекүүд 1995 оноос, казахууд 2021 оноос кирил үсэгийг хэрэглээнээсээ халж, латин үсэгт шилжсэн байна.

3.4. Монгол кирил үсэг. XX зууны эхээр Монгол орон тусхаар тогтонолоо олж, нийгэмийн шинэ хэвшилд шилжиж, гадаад нөлөө, дотоод шалтгааны уламаас орос кирил үсэгийг авч хэрэглэжээ. 1940 оны 7 дугаар сард латин үсэгийг үндэс болгосон шинэ монгол үсэг зохион хэрэглэх тухай Ардын сайд нарын Зөвлөлийн тогтоол гарсаны дагуу 1941 оны 2 дугаар сард монгол хэлний авиа тэмдэглэх 29 үсэгтэй цагаан толгой боловсоруулж, *«Үнэн»* сонины дугаар бүрд латин үсэгийн булан нээж, танилцуулах ажил эхэлжээ. Гэтэл түүнээс ганцхан сарын дараа латин үсэгийн сургалтыг гэнэт зогсоож, *“ЗХУ-ын ард түмэнтэй байгуулсан ах дүүгийн холбоог бэхжүүлэх, тэдний баялаг соёлыг эзэмших”* гэсэн үндэслэлээр *“Орос үсэг дээр үндэслэгдсэн Монголын шинэ үсэгийг батлах тухай”* гэсэн өөр нэгэн шинэ тогтоол гарчээ. Тийнхүү их гүрэний хүчтэй шахалт, засаг төрийн хатуу даалгавараар кирил үсэгийг авч хэрэглэх тухай гэнэтийн шийдвэр гарч, нэн богино хугацаанд кирил үсэгийн зөв бичих дүрэмийг зохиосон ажээ¹. Кирил үсэгт шилжих тухай тогтоолын заалтууд хэрэгжиж хараахан амжаагүй байтал дэлхийн хоёрдугаар дайн эхэлж, нийгэмийн амьдарал, цаг үеийн нөхцөл байдал огцом өөрчилөгдсөн тул кирил үсэгийг хэрэглэх ажил дөрвөн жил орчим тасалджээ. Дэлхийн дайн дууссаны дарааханаас кирил бичигийг сэргээн хэрэглэх ажил эрчимтэй эхэлж, *“Бүх хэвлэл болон албан бичигийг шинэ үсэгээр явуулах тухай”* тогтоол гарч, эхний ээлжинд ихэнхи сонины нэг нүүрийг шинэ үсэгээр гаргаж, 1946 оноос *«Үнэн»* сониныг бүхэлээр нь шинэ үсэгээр гаргах болсоноос гадна бүх шатны сургуулийн сургалтыг шинэ үсэгээр хөтлөн явуулах шийдвэр гарчээ. Монголчууд кирил бичигийг анх авч хэрэглэсэн түүх ийм.

Монголчууд бид кирил бичигийг авч хэрэглэсэнээр харьцангуй богино хугацаанд бүх нийтээрээ бичигтэн болж чадсан төдийгүй, наяд жилийн турш төр засагийн олон талт үйл ажиллагаа, бүх шатны сургуулийн сургалт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээлэлийн хэрэгсэл, соёл урлаг, шинжилэх ухааны олон салбарын бүтээлүүд гагцхүү энэ бичигээр бичигдэж, дэлхийн сонгодог утга зохиол, соёл, шинжилэх ухааны зуу зуун шилдэг бүтээл кирил үсэгээр хэвлэгдэж, бүх нийтийн бичигийн боловсролын түвшингээрээ дэлхийн жишигт хүртэл дээшилсэн билээ. Тийнхүү бид кирил үсэгийг хэл аялгууныхаа нийтлэг шинжид ойртуулан боловсоруулж, наяд жилийн турш албан ёсны бичиг болгон хэрэглэсээр ирсэн учир бусад олон үндэстэний хэрэглэж байгаа кирил бичигээс ялган *‘монгол кирил бичиг’* хэмээн өөриймсүүлэн нэрлэх бүрэн үндэстэй.

¹ Шинэ үсгийг бичих ба хэрэглэх урьдчилсан дүрмийг нэгэн долоо хоногийн дотор боловсоруулан гаргаж зарлах (Ардын Сайд нарын Зөвлөл, Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны тэргүүлэгчдийн 1941 оны 5 сарын 9-ний өдрийн хамтарсан 27 дугаар хурлын тогтоол)

Кирил бичигийг орчин цагийн Төв монгол хэлний Халх аялгуун дээр тулгуурлан боловсоруулсан учир тэр нь өмөнө хэрэглэж байсан сонгодог монгол бичигтэй харьцуулбал ярианы хэлэндээ харьцангуй ойр болсон нь түүний гол давуу тал юм. Зөв бичих дүрэмийг боловсоруулахдаа орос кирил үсэгийн цагаан толгойн 33 үсэгийн дээр монгол хэлэнд өргөн хэрэглэгддэг Ө, Ү үсэгийг нэмэн хэрэглэх болжээ. Кирил үсэгийн зөв бичих дүрэмийн үндэсийг анх боловсоруулахдаа хэл шинжилэлийн үндэслэлтэй, аман яриандаа илүү ойр дүрэм боловсоруулах зорилт тавьж байжээ. Энэ талаар Ц. Дамдинсүрэн *“Ярианы хэлний дууг хайхарахгүй, дууны сургаалыг анхаарахгүй бол ардын ярианы хэлэнд ойрхон шинэ бичигийг зохиох нөхцөлгүй болно”* [аман ярианы хэлний дуудлагыг харгалзахгүй, авиа зүйн судлалыг анхаарахгүйгээр аман ярианы хэлэндээ ойр зөв бичих дүрэм зохиох боломжгүй] (Дамдинсүрэн, 1946.5) гэж тэмдэглэсэн бий. Харамсалтай нь шинэ үсэгийн дүрэмийг боловсоруулах цаг хугацаа нэн давчуу байсан тул зохиогчид санаандаа хүрсэн сайн дүрэм боловсоруулах боломж ололгүй, зөвхөн нөхцөл байдалдаа тохирсон ухаалаг шийдэл, гарц гаргалгаа олох замаар анхны дүрэмийн үндэсийг зохиожээ. Үсэгийн дүрэм зохиох ажилын хэсэгийн ахлагч Ц. Дамдинсүрэн энэ талаар: *“Бид нэг мөсөн бүрэн боловсорсон сайн дүрэмийг зохиож чадахгүй тул алхам алхамаар шат ахиулсаар хожим бүр сайн дүрэмтэй болж чадна”* (1959: 10) хэмээн сайн дүрэм зохиохыг хойч үедээ даалгасан байна. Түүнээс хойшхи наа гаруй жилийн хугацаанд зөв бичих дүрэмийг хэлнийхээ бүтэц, тогтолцоонд ойртуулан боловсоруулах талаар доривтой санаачилга, хичээл зүдхэл огт гарсангүй өдий хүрчээ. Шинжилэх ухааны судалгаанд үндэслэн эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог бодтой зөв тусхасан, тогтвортой, ойлгомжтой, сурахад хилбар, сургахад дөхөмтэй, компьютерт танигддаг зөв бичих дүрэмийн хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байна. Тийм учираас одоо хүртэл хэрэглэсээр байгаа өрөөсхөл дүрэмийг цаг алдалгүй засаж заларуулах нь орчин цагийн монгол бичигийн хэлний тулгамдсан чухал асуудал мөнөөс мөн билээ.

4. Монгол кирил үсэгийн зөв бичих дүрэм

4.0. Ерөнхий асуудал. Ер аливаа хэлний зөв бичих дүрэм нь тухайн бичигийн амид эд эс нь юм. Эд эс нь эрүүл байвал бие махбод нь чийрэг байна. Өөрөөр хэлбэл, зөв бичих дүрэм нь тухайн хэлнийхээ бүтэц, тогтолцоог хэдий чинээ бүрэн зөв тусхасан байвал төдий чинээн тогтвортой, хүртээмжтэй, чадамжтай байна. Үүнтэй холбогдуулан хэл шинжилэлийн онолын нэрт эрдэмтэн Р. А. Будагов *“Зөв бичих дүрэм бол гэрэл зурагийн хальсанд буулгасан амид хэл аялгууны дүрс мөн”* (1971: 299) гэж хэлсэн мэргэн үгийг энд зориуд дурдмаар байна.

Ер аливаа үндэстэний бичигийн хэлний зөв бичих дүрэмийг хэн нэгэн мэргэн хүн зохиодоггүй, мэргэжилийн өндөр түвшинд боловсоруулсан хамтын бүтээл байдаг байна. 1942 онд авч хэрэглэсэн кирил бичигийн зөв бичих дүрэмийг ч бас Ц. Дамдинсүрэн тэргүүтэй тухайн үеийн бичигийн боловсоролтой багш, сэхээтэнүүд хамтаран зохиожээ. Монгол хэлэнд ойртуулан зохиосон кирил бичиг нь манай уласын бүх шатны сургалт, соёл, шинжилэх ухаан, хэвлэл мэдээлэлийн бүх салбарт албан ёсны бичигийн үүрэг гүйцэтгэж, тогтвортой хэрэглэгдсээр ирсэн түүхэн ач холбогдолын талаар өмөнө тодорхой дурдсан билээ. Харин түүний зөв бичих дүрэмд монгол хэлний бүтэц, тогтолцооноос гажсан зүйл цөөнгүй байгаа нь ерөнхий боловсоролын хичээл сургалт, ном сурах бичиг, толь бичигийн боловсоруулалт, хэвлэл мэдээлэл, өдөр дутамын хэрэглээ төдийгүй, компьютерийн програм, эх хэлний бүтэц, тогтолцооны судалгаанд хүртэл сөрөг нөлөө үзүүлсээр ирсэн байна. Хэрэв хэлэндээ тохирсон сайн дүрэм боловсоруулж чадвал буянтай сайн үйл болно. Харин дутуу боловсоруулсан дүрэмийг албадан хэрэгжүүлбэл уршигтай муу үйл болно.

XX зууны эхээр Төв монгол хэлний суурь аялгуу болох халх аман аялгууны авиа зүйн талаар Г. И. Рамстедт, Б. Я. Владимирцов нарын анхны судалгаа гарч, түүний нөлөөгөөр халх аялгууны бүтэц, тогтолцооны талаар илүү нарийвчилсан олон бүтээл гарсан нь зөв бичих дүрэмийн онолын баримжаа болох бүрэн боломжтой.

1957 онд кирил бичиг авч хэрэглэсэний 15 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотноо зохион байгуулсан олон уласын эрдэм шинжилгээний хуралаар кирил бичигийн хэрэглээнд

гарсан нааштай үр дүн болон сөрөг үр дагаваруудын талаар нээлттэй хэлэлцээд, кирил үсэгийн зөв бичих дүрэмийн өрөөсхөл талуудыг цаашид засаж сайжируулах арга замын талаар оновчтой чухал олон санал гарчээ. Тэдгээрийн дотороос зөв бичих дүрэмийн судалгааны үндэс, хэлнийхээ тогтолцоог зөв тусгах талаар гарсан зарим чухал саналуудаас дурдвал: *“Шинжилэх ухааны үндэслэлтэй нарийн судалгаа хийж, сайн нихталан боловсруулах хэрэгтэй”* (Г. Санжеев) // *“Хэлэндээ тохирсон сайн дүрэмтэй болоё”* (Б. Ринчен) // *“Ганц нэгхэн зүйлийг найруулан засах төдий бус, тулгамдсан асуудалуудыг шийдвэрлэх хэмжээнд хүртэл өөрчилөлт оруулах хэрэгтэй”* (П. Аалто) // *“Үсэгийн дүрэмээ тал бүрээс нь боловсруулж, олон түмэний сурахад хилбар болгоё”* (Ш. Лувсанвандан) // *“Хэл аялгууныхаа үндэсэн шинжийг сайтар судалж, уламаар түүнийг дүрэмдээ тусгах нь зүйтэй”* (Чингэлтэй) // *“Амид хэлнийхээ тогтолцоог сайн судлаад, түүндээ дүрэмээ тохируулах ёстой”* (Т. Пагба) // *“16-хан үсэгийг зөв бичихийн тул 134 дүрэм чээжилэх шаардлагатай болсон байна”* (Эрдэнэтөгтох) гэх зэрэг олон санал гарчээ. Түүнчилэн үгийн бүтэцийг зөв тусгах талаар олон санал гарсан бөгөөд энэ талаар хойно тодорхой дурдах болно.

Кирил үсэгийн дүрэмийн үндэсийг анхлан боловсруулсан Ц. Дамдинсүрэн тус хуралыг хааж хэлсэн үгэндээ: *“Шинэ үсгийн бүрэлдэхүүн ба дүрмийн талаар олон сайхан санал сонслоо. Ринчен гуай одоогийн хэрэглэж байгаа шинэ үсгийн дүрмийг гар үйлдвэрт хийсэн муу гуталтай зүйрлэж байна. Энэ үнэн үг шүү. Гэвч сайн гуталгүй учраас муу гутал өмсөхөөс аргагүйн адил сайн дүрэмгүй учир муу дүрэм хэрэглэж байна. Үсэг бичгээ улам сайн болгохын тул одоогийн хэрэглэж байгаа дүрмийнхээ дутагдалтай талыг засаж сайжруулая. Энэ зорилгыг амжилттай шийдвэрлэхийн тул цагаан толгойн бүрэлдэхүүнд зарим нэгэн өөрчлөлт оруулая гэсэн эрмэлзэл бол үнэхээр зүй ёсны санал юм”* гэжээ. Үүнээс үзвэл үсэгийн бүрэлдэхүүнээ өөрчилж, дүрэмээ сайжируулах саналыг Ц. Дамдинсүрэн гуай бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байсан нь тодорхой харагдаж байна. Тэрбээр хожим *“Шинэ үсгийн дүрэмд битүүлэг зүйл үлэмжхэн бөгөөд улам тодорхой болгох нь хэл бичгийн ажилтны үүрэг... Энэ удаагийн боловсруулсан дүрэмд дутуу дулим зүйл үлэмжхэн байгаа”* (1959: 10) хэмээн дурдсан бий.

Хэрэв тус хурал дээр гаргасан оновчтой саналуудыг ‘хэл бичигийн ажилтанууд’ тэр даруйд нь хүлээн авч, үсэгийн дүрэмдээ бүтээлчээр тусхасан бол бид өдийд үсэгийн дүрэмийн дутагдалын тухай улиглан ярих биш, үсэг бичиг дээр суурилсан компьютерийн олон төрөлийн программын тухай, тэдгээрийг хэрхэн төгөлдөржүүлэх тухай асуудал ярьж байх ёстой байлаа. Харамсалтай нь түүнээс хойш жар гаруй жил өнгөрч, шинжилэх ухааны олон салбар эрчимтэй хөгжиж, үсэг бичиг, бичигийн хэлний төгөлдөржилт нэн шаардлагатай болсон боловч зөв бичих дүрэмийг боловсоронгуй болгох асуудал бараг хөндөгдсөнгүй, хааяа замын цоорхойг шавар зуурмагаар бөглөхийн адил ганц хоёрхон үгийг өөрчилөх төдийхөнөөр хизгаарлаж, наян жилийн өмөнө гарсан өрөөсхөл дүрэмийн зарчмыг хэвээр нь хадгалсан толь бичиг дахин дахин үйлдвэрлэхээс хэтэрсэнгүй.

Кирил үсэгийн бодит хэрэглээн дээр тохиолдож байгаа бэрхшээлийн талаар бага, дунд сургуулийн багш нар, сонин хэвлэлийн ажилтанууд 1960-70-аад оны үеэс удаа дараа санал бодолоо илэрхийлсээр байлаа. Тэр бүхэнийг харгалзан 1975 онд Намын Төв Хорооноос кирил үсэгийн дүрэмийг сайжируулах тухай санал боловсруулахыг ШУА-ийн Хэл Зохиолын Хүрээлэнд албан бичигээр даалгасан байдаг. Тухайн үед тус Хүрээлэнгийн захирал байсан профессор А. Лувсандэндэв цөөн хүнтэй ажилын хэсэг бүрдүүлж, өмөнөх эрдэмтэдийн гаргасан оновчтой саналуудыг харгалзан үг зүйн зарчмыг суурь болгож, үгийн бүтэцийг эвдэхгүй бичих төсөл боловсруулаад, Намын Төв Хорооны нарийн бичигийн дарга нарын газарт хүргүүлсэн билээ. Энэ үгүүлэлийг бичигч тэрхүү дүрэмийн үндэсийг боловсруулах ажилд биечилэн оролцсон бөгөөд уг төсөл удахгүй хэрэгжинэ гэсэн бат итгэл үнэмшилтэй байсан билээ. Төдөлгүй миний бие Токио хотын Гадаад судлалын Их сургуульд томилогдон очсоныхоо дараа монгол-англи хэлний шинэ толь бичиг эмхэдхэхдээ шинэхэн боловсруулсан дүрэмийнхээ үндэсийг баримтлан үгийн язгуур-дагавар, үндэс-нөхцөлийн бүтэцийг эвдэлгүйгээр бичсэн билээ. Энэ тухайгаа тус толь бичигийн өмөнө *“Монгол хэлний үгийн бүтэц, тэдгээрийн бодит дуудлагыг аль болохоор зөв тусгахын тул БНМАУ-д одоогоор мөрдөж байгаа үсэгийн дүрэмээс өөрөөр тэмдэгэлсэн үг нилээд бий. Гэвч тэдгээр нь ойрын*

үед БНМАУ-д одоогийн дагаж байгаа үсэгийн дүрэмд оруулах зарим өөрчилөлттэй үндэсэндээ тохирно гэж бодож байна” хэмээн дурдаад, одоогийн бичлэгээс зөрөөтэй бичигдсэн 950 гаруй үгийн жагсаалтыг тус толь бичигийнхээ ард хавсаргасан бий. Гэтэл бид бүхэний хүлээж байсан дүрэмийн өөрчилөлт хэрэгжих нь байтугай, харин би гэдэг хүн “Намын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 1941 оны 3-р сарын 25-ны өдөр 22/18 тоот тогтоолоор баталж, улс орон даяар нэгэн мөр даган мөрдөж байгаа шинэ үсэгийн тогтсон дүрэмийг нам засагийн удирдах байгуулгын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн засварлаж, хөрөнгөтөн оронд хэвлүүлсэн” харш үзэлтэн болж буруудаад, эрдэмийн зэрэг хамгаалах, гадаадад явах эрхээ бүтэн арван жилээр хасуулсан билээ. Тэр явдал нь шинэ бичигийн зөв бичих дүрэмийг засаж сайжируулах бодолтой байсан хүмүүст энэ асуудалаас холхон байхыг сануулсан дохио болсон юм. Тийм ч учираас тэр үед “Үйлээ эрсэн хүн үсэгийн дүрэмээр оролдоно” гэсэн хэлц үг хүртэл гарч, “үйлээ эрсэн хүн” дахиад гараагүй. Харин одоо бол зөв бичих дүрэмээ засан сайжируулах хичээл зүдхэл гаргавал уридынх шиг ял зэм хүртэхгүй, гавьяатай сайн үйлийн эзэд болно.

Тэрхүү будилаант явдалаас хойшхи хагас зуун жилийн хугацаанд нийгэмийн тогтолцоо өөрчилөгдөж, хүн ард нь үзэл сурталын хүнд дарамтаас ангижирч, санаа бодолоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэн сайн цаг эхэлж, боловсорол, шинжилэх ухааны бүх салаа салбар цаг үеийн шаардлагаар өөрчилөгдөн шинэчилэгдлээ. Гэтэл хамагийн түрүүнд шинэчилэгдэх шаардлагатай зөв бичигийн дүрэм маань наян жилийн өмөнөх байдалаа хэв хэвээр нь, бат тогтвортой хадгалсаар үлджээ.

Ер аливаа бичигийн зөв бичих дүрэм нь зөвхөн мэдээлэл дамжуулах дохионы тэмдэг, албадан мөрдүүлэх болзмол дүрэм бус, тухайн хэлнийхээ бүтэц, тогтолцоог шинжилэх ухааны үндэслэлтэй тусхасан байх шаардлагатай байдаг байна. Тийм учираас хэлнийхээ бүтэц, тогтолцоонд бүрэн тохирохгүй өрөөсхөл дүрэм үйлчилсээр байгааг цаг алдалгүй засаж заларуулах ажил хүлээгдсээр байна.

1990-ээд оноос сонин хэвлэл, мэдээ мэдээлэл, албан бичиг захидал, ном хэвлэлүүд одоо мөрдөж байгаа зөв бичих дүрэмээ ч харгалзалгүй, нэг үгийг хэд хэдэн өөр хувилбараар бичих нь ерийн зүйл болсон билээ. Бас заримдаа “гээгдэх эгшигийн дүрэм”-ийг зөрчиж ‘зөв’ бичсэн тохиолдол ч гарч байна. Энэ нь нэг талаас, одоогийн зөв бичих дүрэм нь өнөөгийн өсөн нэмэгдэж байгаа бичигийн хэлний хэрэгцээ шаардлагаас хоцорч байгаатай, нөгөө талаас, иргэн бүр үзэл бодолоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний илэрхийлэлтэй холбоотой буй заа.

Кирил бичигийн хэрэглээний талаар олон түмэнээс удаа дараалан гарч байгаа санал шүүмжүүдийг эрхбиш харгалзан 2003 онд кирил үсэгийн зөв бичих дүрэмийн толь бичиг боловсруулах засагийн газарын шийдвэр гарсан билээ. Уг нь эхлээд зөв бичих дүрэмээ засаж сайжируулаад, дараа нь түүнийгээ тусхасан толь бичиг гаргах ёстой сон. Харамсалтай нь тэгсэнгүй. Дээрхи шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан ажилын хэсэгийн гишүүд “зөв бичих дүрэмийн толь бичиг гаргахын өмөнө дүрэмээ засаж сайжируулах шаардлагатай байна” гэсэн зүй ёсны бүтээлч санал дэвшүүлээд, үг зүйн зарчмыг голлож, авиа зүйн зарчмыг харгалзсан арга зүй боловсруулж, түүнийхээ дагуу үгийн язгуур, үндэс хийгээд дагавар, нөхцөлүүдийн бүтэцийг хадгалсан зөв бичих дүрэмийн төсөл боловсруулсан билээ. Шинэчилэн боловсруулсан тэрхүү төсөлд одоо мөрдөж байгаа 130 гаруй дүрэмээс хэрэглээ багатай, зохиомол шинжтэй 80 гаруй дүрэмийг хасаж, цэг тэмдэгийн дүрэмийг оролцуулан 40 орчим дүрэм, 9 хүснэгт боловсруулсан нь сурахад амархан, сургахад хилбар болсон төдийгүй, монгол бичигтэй хөрвөх програм боловсруулахад ч илүү дөхөмтэй болсон билээ. Ажилын хэсэгийнхэн өөрсөдийн боловсруулсан төсөлөө бүх шатны сургуулийн мэргэжилийн багш нарын төлөөлөл болон Төрийн хэлний Зөвлөлөөр хэлэлцүүлээд эцэст нь тухайн үеийн БСШУ-ны яаманд өргөн барьсан боловч дахиад л нам дарагдаад өнгөрсөн нь нэн харамсалтай. Таширамд дурдахад тус ажилын хэсэгийн гишүүд нэг ч дүрэмийг шинээр зохиогоогүй, зөвхөн өмөнөх эрдэмтэдийн гаргасан оновчтой саналуудыг тусхасан болно.

Зөв бичих дүрэмийг засан сайжируулах асуудал тийнхүү бүтэлгүйдсэн боловч үсэгийн дүрэмийг тогтвортой болгох тухай санал хүсэлтүүд БСШУЯ болон Засагийн газарт тасаралтгүй очсоор байсан тул 2013 онд “Монгол хэл бичигийн боловсролыг сайжируулах арга хэмжээ”-ний тухай Засагийн газарын 37-р тогтоол гарч, түүндээ мөн л монгол кирил бичигийн

үсэгийн дүрэмийн журамласан толь боловсоруулах тухай тусхайлан заасан байв. Тус тогтоолын заалтыг хэрэгжүүлэх мэргэжилийн комисс байгуулагдаж, арван жилийн өмөнө боловсоруулсан дүрэмийнхээ үндэсийг баримтлан зарим нэгэн нэмэлт засвар оруулж, уламаар шинэчилэн боловсоруулсан дүрэмдээ тохирсон 44900 үг бүхий зөв бичих дүрэмийн толь бичиг эмхэдхэн боловсоруулаад тухайн үеийн БСШУ-ны сайдад гардуулан өгсөн боловч бас л уридын адил дарагдаад өнгөрсөн гашуун түүх бий. Толь ч байхгүй, дүрэм ч байхгүй.

2018 онд тухайн үеийн Монгол Уласын Ерөнхийлөгчийн дэргэдэх тамгын газрын даалгавараар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд өөр нэгэн ажилын хэсэг зохион байгуулж, 38000 үгтэй “Монгол хэлний зөв бичих дүрэмийн журамласан толь”-ийг эмхэдхэн нийтлүүлжээ. Уласын ерөнхийлөгч нь шийдвэрээ гаргаж, тамгын газар нь санхүүгээр дэмжиж, ихээхэн хөрөнгө хүч, техник хангамж, цаг хугацаа зарцуулан байж эмхэдхэсэн тус толийн ажилын хэсэг кирил үсэгийн зөв бичих дүрэмийг сайжируулах талаар ганц ч алхам хийгээгүй нь харамсалтай. Тамгын газараас хуучин дүрэмээ дагаж мөрдөхийг чиглэл болгосон учир яалтай билээ. Шинжилэх ухааны хөгжилд төрийн дэмжлэг чухал боловч төрийн оролцоо огт хэрэггүй. Боловсоронгуй бичигийн хэлний хэрэгцээ шаардлага нэн чухал болж байгаа энэ эрин цагт эх хэлнийхээ бүтэц, тогтолцоог судалгааны үндэслэлтэй тусхасан зөв бичих дүрэмийн журамласан толь л чухал болохоос биш дал, наян жилийн өмөнөх хуучин дүрэмийн толио дахин дахин хэвлэх нь ямар тустай гэж?! Ер журамласан толь хэрэглэнэ гэдэг бол хэлнийхээ бүтэц, тогтолцооноос гажсан хуучин дүрэмээ хууль мэт дархална гэсэн үг бус, хэлэндээ тохирсон сайн дүрэмийг бүх нийтээрээ дагаж мөрдөх гарын авлага болгоно гэсэн үг.

Ер аливаа хэлний зөв бичих дүрэмийн толь бичиг нь хүн бүрийн өдөр дутамын хэрэгцээг хангаж байдагийнхаа хувид хэрэглэгч бүрийн гарын авлага, ширээний ном болж байдаг. Дүрэмийг нь санахгүй, утгыг нь мэдэхгүй үг хэллэг тохиолдох бүрд толио ашигладаг. Шаардлагатай үедээ толь бичиг ашиглана гэдэг бол мэдлэггүй хүний үйлдэл биш, соёлтой хүний хэрэглээ юм. Иргэн бүхэн нь өндөр боловсоролтой Герман уласын энгийн иргэнээс аваад сэдхүүлч, зохиолч, эрдэмтэн профессор бүхэн “*Die kleine Duden Wörterbuch*” // “*Duden: Deutsches Universal Wörterbuch A-Z*” // “*Düden: Das grosse Wörterbuch der deutschen Sprache*” гэх мэт толь бичигийг ширээн дээрээ тавьж, байнга хэрэглэж байдаг. Бидэнд тийм л толь бичиг хэрэгтэй. Тийм толь бичиг одоо хүртэл гараагүй байгаа нь түүний баттай суурь болох сайн дүрэм боловсороогүйтэй холбоотой. Сайн дүрэм боловсоруулахаас зайлсхийсээр ирсэний учир нь доорхи хоёр гол шалтгаантай.

А. Өмөнөх тогтолцооны үед гэвэл Зөвлөлт ахын үсэг бичигийг нам төрийн дээд удирдлагын шийдвэрээр авч хэрэглэсэн тул түүнийг засаж өөрчилөх тухай асуудалыг хөндвөл улас төр, үзэл сурталын ноцтой асуудал болдог байлаа.

Б. Өнөө үед гэвэл, дасаж дадсан дүрэмээ өөрчилөхөөс түвэгшээх нь нийтлэг шинжтэй. Түүнээс гадна шинэ дүрэм гарвал сурагчидын сурлагын хувь буурч, ажилын үзүүлэлт, хувийн нэр хүндэд халтай гэсэн хандлага мэргэжилийн багш нараас аваад боловсролын удирдлагын түвшинд ч бас бий. Түүнчилэн үсэгийн дүрэмийн өөрчилөлттэй нэр холбогдвол сошиалын бай болж, элдэв дайралтад өртөнө гэж болгоомжиллох, дүрэм харгалзахгүй, дур зоргоороо бичих нь хувь хүний эрх чөлөө мэтээр сэдхэх нь ч бас бий.

Хэрэглээний талаас авч үзвэл, хэлэндээ тохирсон дүрэмтэй болж чадвал алхам дутамд түвэг учруулдаг зохиомол дүрэмүүдээс салж, сургахад хилбар, сурахад дөхөмтэй цөөн тооны үндэсэн дүрэмтэй болох төдийгүй, компьютерийн системд амархан танигдаж, бусад үсэг бичигтэй хөрвөх чадамж нь илүү дөхөмтэй болно. Онолын талаас авч үзвэл, хэлнийхээ бүтэц тогтолцоонд харьцангуй ойр, хэл шинжилэлийн үндэслэлтэй, илүү боловсоронгуй, илүү тогтвортой дүрэмтэй болж чадна гэсэн үг.

Одоогийн мөрдөж буй кирил бичигийн зөв бичих дүрэм нь бүхэлдээ өрөөсхөл биш, юуны өмөнө, үсэгийн дүрэм боловсоруулах үндэсэн зарчимаа өрөөсхөл тогтоосоноос гадна цагаан толгойн үсэгийн бүрэлдэхүүнийг оновчтой тогтоогоогүй, нөгөө талаар, хэлнийхээ бүтэцийг гажуудуулахад хүрсэн ‘гээгдэх эгшиг’-ийн дүрэмийг зохиосон. Эдгээр шалтгааны уламаас тухай тухайн нөхцөлд тохируулсан олон дүрэмийг зохиосон нь нэг талаас зөв гаргалгаа мэт

боловч нөгөө талаар үсэгийн дүрэмээ тодорхой тогтолцоогүй болгоход хүрчээ. Тухайн үеийн нийгэм, улас төрийн нөхцөл байдал, гэнэтийн шийдвэр, цаг хугацаа зэрэг олон шалтгааны уламаас илүү сайн дүрэм боловсоруулах бодит боломж байгаагүй учир түүнд байгаа өрөөсхөл талуудыг тухайн дүрэмийн үндэсийг боловсоруулсан зохиогчид тохон буруудхах үндэслэлгүй, харин ч нийтээр хэрэглэх албан ёсны бичигийн хэлний үндэсийг тавьсан гавьяаг үнэлэх ёстой билээ.

Эдүгээ бидний хэрэглэж байгаа монгол кирил бичигийн зөв бичих дүрэмийн дутагдалтай өрөөсхөл тал нь 1. авиа зүйн зарчмыг голлож, үг зүйн зарчмыг огоорсон, 2. хэлэндээ тохирсон үсэг сонгож чадаагүй, 3. Авианы байрлалыг ноцтой зөрчсөн “гээгдэх эгшигийн дүрэм”-ийг зохиосон. Энд бид дээр дурдсан гурван асуудалыг дэд сэдэв болгон тус тусд нь авч үзэхийг зорив.

4.1. Үсэг зүйн зарчмын талаар. Кирил бичигийн дүрэмийг анх боловсоруулахдаа үг зүйн зарчмыг баримталж, авиа зүйн зарчмыг орхигдуулсанаас үгийн бүтэц эвдэрсэн нь цөөнгүй байна. Тухайлбал, үгийн язгуур, үндэс, дагавар, нөхцөлийн бүтэц эвдэрч, нэг үг хоёр өөр үндэстэй бичигдэх болсон нь кирил үсэгийн дүрэмийн тогтолцоог ойлгомжгүй болоход хүргэж байна. Тийм учираас кирил үсэгийн зөв бичих дүрэмийг цаашид засан сайжируулахын тул юуны өмнө, үг зүйн зарчмыг голлож, үгийн бүтэцийг эвдэхгүй бичдэг болох нь чухал гэсэн саналыг Ш. Лувсанвандан, Э. Вандуй, Эрдэнэтогтох, Я. Цэвэл, Д. Чойжилсүрэн, Г. Санжеев, Ж. Надмид нар дэвшүүлсэн байна.

Онолын талаас авч үзвэл, залгамал бүтэцтэй монгол хэлний хувид үг зүйн зарчмыг голлож, авиа зүйн зарчмыг оновчтойгоор харгалзан үзсэн зөв бичих зүй боловсоруулах нь нэн тохиромжтой. *Үг зүйн зарчим* гэдэгт язгуур-дагаварын бүтэц, үндэс-нөхцөлийн бүтэц багтахгаас гадна хэл зүйн холбох нөхцөлүүдийн бүтэц ч бас багтана. *Авиа зүйн зарчим* гэдэгт авианы байрлалтай холбоотой асуудалууд багтана. *Авианы байрлал* гэдэгт нэгэн үгийн доторхи эр, эм эгшигийн зохицол хийгээд үеийн заагт залган орох гийгүүлэгчийн тогтсон дараалал багтана. Эдгээр хоёр зарчмыг зохистой хослуулж чадвал үгийн бүтэц ч эвдэгдэхгүй, авианы байрлал ч алдагдахгүй.

4.2. Үсэгийн бүрэлдэхүүн. Аливаа бичигийн үсэгийн бүрэлдэхүүн нь тухайн хэлнийхээ авианы үндэсэн бүрэлдэхүүнтэй тохирч байх ёстой. Гэтэл монгол кирил үсэгийн цагаан толгойн үсэгүүдийг эх хэлнийхээ авианы үндэсэн бүрэлдэхүүнтэй тохируулан тогтоосонгүй, орос хэлний авианы бүрэлдэхүүнд тохируулан тогтоосон 33 үсэгийг огт өөрчилөлгүй авч, дээр нь зөвхөн Ө, Ү гэсэн хоёрхон үсэг нэмжээ. Тиймээс монгол хэлний авиаг тэмдэглэхэд оролцоо багатай нилээд үсэг (Е, Ё, Ю, Я, Й, Ь, Ъ, Ф, Щ)-ийг цагаан толгойнхоо бүрэлдэхүүнд багтаасан учир тэдгээрт тохирсон зохиомол дүрэм бий болгосон нь кирил үсэгийн зөв бичих дүрэмийг ихээхэн будилаантуулжээ. Тухайлбал, дан авиа тэмдэглэдэг үсэгүүдийн дотор бүхэл бүтэн үе тэмдэглэдэг Е, Ё, Ю, Я үсэгийг оруулсан нь зарчмын хувид тохирохгүйгээс гадна *уё, уй* гэсэн үеийг тэмдэглэх үсэг огт байхгүй орхигдсон учир *yös, yöröl, yüüden, yүүл*- гэх мэт үгсийг арга буюу ЕС [yes], ЕРӨӨЛ [yeröl], ЮҮДЭН [yuüden], ЮҮЛ- [yuül] гэх мэтээр аргацаан тэмдэглэсээр иржээ. Түүнчилэн орос бичигт зөвхөн тэмдэгийн үүрэгээр хэрэглэгддэг Ъ, Ь-ийг заримдаа авианы үүрэгээр, заримдаа тэмдэгийн үүрэгээр хэрэглэсээр байна. Тодорхой үүрэггүй Й үсэгт хос эгшиг тэмдэглэх үүрэг ноогдуулжээ.

1957 онд болсон эрдэм шинжилгээний хурал дээр кирил бичигийн цагаан толгойн бүрэлдэхүүнтэй холбогдуулан гаргасан саналуудаас дурдвал: “*үсэгийнхээ бүрэлдэхүүнийг хэлэндээ тохируулж чадаагүйгээс түмэн зүйлийн будилаан гарчээ*” (Б. Ринчен) // “*хэлээ үсэгэндээ тохируулах бус, үсэгээ хэлэндээ тохируулах ёстой. Цагаан толгойн бүрэлдэхүүнд зохих өөрчилөлт оруулахгүйгээр сайн дүрэм боловсоруулж чадахгүй*” (П. Аалто) // “*орос цагаан толгойн бүх үсэгийг авсан учир тэдгээрт зориулсан олон илүү дүрэм гарсан байна. (Я. Цэвэл) // “дүрэмээ сайжируулахын нэг гол үндэс нь үсэгийн бүрэлдэхүүнд өөрчилөлт оруулах*

явдал юм” (Ж. Надмид) // “өөрийн хэлэнд байхгүй я, ё, е, ю, ь, ъ, иц үсэгүүдийг хасвал зохино” (Э. Вандуй, Б. Ц. Цыдендамбаев, Я. Цэвэл, Ж. Надмид, Д. Чойжилсүрэн, Эрдэнэтогтох, Н. Жамбалсүрэн, Б. Содном, Гэрэлцогт) гэх мэт. Дээрхи эрдэмтэдийн гаргасан оновчтой саналуудыг үндэслэн цаашид цагаан толгойн үсэгийн бүрэлдэхүүнийг эх хэлнийхээ авианы бүрэлдэхүүнтэй дүйцүүлэн сонгоод, хэрэгцээгүй зарим үсэгийг хасвал зөв бичих дүрэм илүү хилбар болно. Үүнтэй холбогдуулан дараах хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

4.2.1. Я-гийн төрөлийн үсэг. Кирил үсэгийн зөв бичих дүрэмийн үндэсийг боловсруулсан Ц. Дамдинсүрэн Я-гийн төрөлийн үсэг авсанаар үсэгийн дүрэмд бэрхшээл учируулж байгаа талаар: “Я, Е, Ё, Ю дөрвөн үсэг бол гийгүүлэгч, эгшиг хоёроос бүтсэн ЙА, ЙЭ, ЙО, ЙҮ дуудлагатай бүхэл үеийг тэмдэглэх үсэг учир ... үсгийн дүрэм ээдрээтэй болж, улмаар эгшиг, гийгүүлэгчийн дүрэм ч төвөгтэй боллоо” хэмээн тэмдэглэсэн байна. Монгол хэлний авианы бүрэлдэхүүн болон үсэгийн дүрэмийн тогтолцоонд тохиромж муутай Я-гийн төрөлийн үсэгүүдийг кирил үсэгийн бүрэлдэхүүнээс хасаж, өөр үсэгээр орлуулах тухай хэд хэдэн санал гарсан байна. Тухайлбал: Ш. Лувсанвандан, Я. Цэвэл нар латин бичигийн J үсэгийг авч *ja, je, ji, jo, ju, jö, jü* гэж тэмдэглэх санал гаргасан бол Ц. Дамдинсүрэн, П. Аалто, Б. Ц. Цыдендамбаев нар кирил үсэгийн Й үсэгийг авч *йа, йэ, йо, йу, йө, йү* хэмээн тэмдэглэх санал дэвшүүлсэн бий. Тийм учираас цаашид цагаан толгойнхоо бүрэлдэхүүнээс Я-гийн төрөлийн үсэгийг хасая гэвэл дээрхи саналын аль нэгийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Я-гийн төрөлийн үсэгийг латин бичигийн Y үсэгээр тэмдэглэх илүү боломж байгаа боловч тэр нь кирил бичигийн У үсэгтэй дүрс адил учир будилаан үүснэ.

4.2.2. Ъ-ийн тухай. Уулаасаа бие даасан авиа (авиалбар) тэмдэглэдэггүй Ъ-г цагаан толгойн бүрэлдэхүүнээс хасах саналыг Ш. Лувсанвандан, Я. Цэвэл, Э. Вандуй, Б. Содном, П. Аалто, Эрдэнэтогтох нар гаргасан байна. Дээрхи саналыг үндэслэн цаашид түүнийг хасаж, оронд нь эгшиг зохицолын дагуу аль сонсогдох эгшигийг (*явая, ороё, өгөө, угтая* г. м.) бичих бүрэн боломжтой. Таширамд тэмдэглэхэд, Ш. Лувсанвандан үгийн эцэсийн битүү үеийн заримдаг хэлбэржсэн балархай эгшигүүдийг *дарлагдъл, холбогдъл, элэгдъл, үзэгдъл* гэх мэт Ъ-ээр тэмдэглэсэнээс үзвэл түүгээр үе бүтээх балархай эгшигийг тэмдэглэх боломжтой юм. (Монгол хэлний халх аялгууны балархай эгшигийн тухай асуудалд, ШУАМ 2, 1964, 88-83)

4.2.3. Ь-ийн тухай. Орчин цагийн монгол хэлэнд *tar* (тар) ~ *tar'* (тарь), *bar* (бар) ~ *bar'* (барь), *hol* (хол) ~ *hol'* (холь), *am* (ам) ~ *am'* (амь), *han* (хан) ~ *han'* (хань) гэх мэтээр тагнайшсан болон эс тагнайшсан гийгүүлэгч нь тус тусдаа авиалбарын утга ялгаж байгаа тул тэдгээрийг ялгаж бичих нь үсэгийн дүрэмийн нэг давуу тал юм. Тийм учираас кирил үсэгийн дүрэмд хэвшин тогтсоныхоо дагуу цаашид ч тагнайшсан гийгүүлэгчийг Ь-ээр ялган тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Хэрэв тагнайшсан гийгүүлэгчтэй үгэнд нөхцөл, дагавар нэмэн залгах болвол Ь-ийг И-гээр солих шаардлагагүй, *тарьяа, барьуул, хольих, амьид, аньих, ханьяа* гэх мэтээр шууд залган бичих боломжтой. Одоогийн дүрэмд Ь-ийг И-гээр сольж *тариа, хорио, хариу* гэх мэтээр бичихэд авиа зүйн хувьд ч, үгийн бүтэцийн хувьд ч зөрчил гардаг. Бодит байдал дээр тагнайшсан гийгүүлэгчийн дараа урт *аа, оо, уу* гэх мэт урт эгшиг бүхий үг бүтээх дагавар залгаж байхад өмөнө талын тагнайшсан гийгүүлэгч ч тэмдэглэгдэхгүй, урт эгшигээс бүтсэн дагавар ч тэмдэглэгдэхгүй, харин монгол хэлэнд огт байхгүй *иа, ио, уу* гэх мэт хос эгшиг гарч ирэхэд хүрчээ. Харин түүний оронд *тарьяа, хорьоо, харьуу* гэж бичвэл тагнайшсан гийгүүлэгч ч тэмдэглэгдэнэ, түүний арын бүтээвэр ч тэмдэглэгдэнэ. Нэмэн дурдахад: Ь нь нэгэнт тэмдэг үсэг учир тагнайшсан гийгүүлэгчээс гадна үгийн эцэсийн үе бүтээх хэт балархай эгшигийг давхар тэмдэглэж ч бас болно.

4.2.4. Хэлний хойгуурхи *й*, урдуурхи *п* гийгүүлэгч. Монгол кирил бичигт хэлний хойгуур, хамаршсан *й*, хэлний урдуур, хамжих *п* гэсэн хоёр өөр авиа (авиалбар)-г нэг үсэгээр тэмдэглэсээр иржээ. Уулаасаа өөр өөр байрлалд, өөр өөр аргаар хэлэгддэг биеэ даасан энэ хоёр авиалбарыг өөр өөр үсэгээр ялгаж бичих шаардлагатай бөгөөд ийм саналыг Б. Ринчен, Э. Вандуй, Б. Содном, Чингэлтэй нар гаргасан байна. Таширамд дурдахад, дээрхи хоёр өөр гийгүүлэгчийг орчин үеийн халимаг бичигт тэдгээрийг *н, н* гэсэн өөр хувилбар үсэгээр ялган тэмдэглэсэнээс гадна авиа зүйн адил тогтолцоотой Башкир, Каках, Киргиз, Тува, Чуваш, Якут

зэрэг түрэг хэлтэн болон Эвенки, Нанай зэрэг түнгүүс бүлэгийн хэлэнд дээрхи хоёр авиаг мөн л өөр өөр үсэгээр ялган тэмдэглэсэн байна.

4.2.5. Хэлний хойгуурхи *ǵ*, хэлний урдуурхи *g* гийгүүлэгч. Кирил бичигт хэлний хойгуур хамжих *ǵ*, хэлний урдуур хамжих *g* гэсэн хоёр өөр авиа (авиалбар)-г мөн л нэг үсэгээр тэмдэглэсээр иржээ. Уулаасаа өөр өөр байрлалд, өөр өөр аргаар хэлэгддэг биеэ даасан энэ хоёр авиалбарыг өөр өөр үсэгээр ялгаж бичих шаардлагатай бөгөөд ийм саналыг саналыг Б. Ринчен, Б. Содном, Б. Ц. Цыдендамбаев, Чингэлтэй нар гаргасан бий. Хэлэгдэх шинжээрээ илт ялгаатай энэ хоёр гийгүүлэгчийг монгол хэлтэй адилавартар тогтолцоотой Азербайжан, Башкир, Үзбек, Хакас, Чуваш, Якут хэлтэнүүд өөр өөрийн бичигтээ хэлний угийн Г авиаг *ǵ/ḡ* гэсэн тусхай үсэгээр ялган тэмдэглэсэн байна.

Дуудагдах шинж, үгүүлэгдэх байраараа ялгаатай *ŋ, n* болон *ǵ, g* хоёр авиалбарыг өөр өөр үсэгээр ялган бичих нь монгол хэлний авианы тогтолцоог зөв тусгах талаараа ч, зөв бичих дүрэмийг илүү тодорхой болгох талаараа ч эерэг сайн талтай билээ.

Нэмэлт тэмдэглэл. Монгол үгийн бичлэгт ордоггүй Ц, Ф болон өмөнө дурдсан Е, Ё, Ю, Я, Ъ, Ь-ийг гадаад хэлний үг тэмдэглэдэг тусхай үсэгийн бүлэг болгон үлдээх нь монгол кирил үсэгийн чадамжийг хадгалахад тустай. Өөр нэг дурдууштай зүйл бол орос хэлэнд хэлний урдуурхи *ŭ* авиа тэмдэглэдэг У үсэгээр монгол хэлэнд хэлний хойгуур хэлдэг *u* авиа тэмдэглэх болсон нь монгол хэлний хувьд тодорхой зөрчилгүй ч гэсэн орос хэлэнд хэлний урдуурхи *ũ* эгшигээр хэлэгддэг *Пушкин, Узбек, Турк, русский, урок* гэх мэт үгсийг *Púškin, Uzbék, Túrka, Rússkij, urók* гэж хэлний хойгуурхи эгшигээр дуудахад хүрч байна. Тийм ч учираас монгол кирил бичигийн У, Ү хоёр үсэгийг хооронд нь солих нь зүйтэй гэсэн саналыг профессор Б. Ц. Цыдендамбаев гаргасан бий.

Жич: Тогтсон хэдхэн үсэгтэй бичигийн машин өдөр дутамын хэрэглээнээс гарч, ямар ч үсэг тэмдэгт ашиглах боломжтой компьютер хэрэглэх болсон энэ цагт хэрэгцээтэй үсэгээ сонгож хэрэглэх боломж бүрэн бүрдсэнийг дурдая.

4.3. Үсэгийн дүрэм

4.3.1. Авианы байрлал. Хэл бүхэн авианы хатуу тогтсон байрлалтай байдаг ажээ. Залгамал бүтэцтэй монгол хэлний нэгэн үгэнд дараалан орсон авианууд тогтсон тодорхой байрлалтай байдаг бөгөөд тэдгээрийн байрлалыг хүн зохиодоггүй, үгүүлэх эрхтэний үйл ажиллагааны бодит боломж тогтоодог юм. Монгол хэлний авианы байрлалыг монгол хэл шинжилэлд ‘*зохицол*’ хэмээн нэрлэдэг. Хэлний авианы зохицол нь тухайн хэлнийхээ үсэг бичиг, түүний зөв бичих дүрэмд бодтойгоор туссан байх ёстой.

4.3.1.1. Эгшиг авианы байрлал Монгол хэлний эгшиг авианы байрлал гэдэг нь нэгэн үгийн доторхи эгшиг авиануудыг дуудахад үгүүлэх эрхтэний булчингийн чангарч, сулрах хүчдэлийн шинж дээр тулгуурласан ангилал юм. Тодоруулан хэлбэл: хэлний хойгуурхи (эр) эгшигийг дуудахад хэлний хойд хэсэгийн булчин агшиж чангардаг бол хэлний урдуурхи (эм) эгшигийг дуудахад хэлний булчин ерөнхийдөө сул байдаг ажээ. Нэгэн үгийн доторхи эгшигүүд нь хэл ярианы урасхалд эр, эм шинжээрээ зохицон хэлэгдэх дараалалыг монгол хэл шинжилэлд “*эгшигийн зохицол*” хэмээн нэрлэдэг билээ. Хэлний хойгуур, урдуурхи эгшигийн аль алинтай нь зохицон хэлэгддэг эгшигийг *эрэс эгшиг* хэмээн нэрлэдэг бөгөөд тэр нь хэлний хойгуур, урдуур хэлэгдэх эгшигээс гадна гурав дахь эгнээ үүсгэдэггүй байна. Тийм учираас эрэс эгшигийг уламжилалт хэл шинжилэлд “*урвах эрэс*” хэмээн нэрлэдэг ажээ. Монгол кирил бичигийн зөв бичих дүрэм нь эгшиг авианы байрлалыг зөрчсөн зүйлгүй.

4.3.1.2. Гийгүүлэгч авианы байрлал. Монгол хэлний гийгүүлэгч авианы байрлал нь эгшиг авианы адил цуvaraх дараалалаараа зохицдоггүй, зөвхөн үгүүлэгдэх шинж болон байрлалаараа зохицдог байна. Монгол хэлний бүх гийгүүлэгчийн дотороос зөвхөн хэлний урдуур хамжих Г, К гийгүүлэгч нь бүр эртний монгол хэлний үеэс гагцхүү эм эгшигт хэлэгдэж байсан нь уйгуржин монгол бичиг болон монгол дөрвөлжин бичигт тодорхой туссан байдаг билээ. Харин

орчин цагийн монгол хэл аялгуунуудын хувьд гэвэл, тэрхүү G, K нь эдүгээгийн ойрод, халимаг хэлэнд хэвээрээ хадгалагдан үлдсэн бөгөөд бусад монгол хэл аялгуунуудад их төлөв шүргэх **х, h** болсон байна.

Монгол хэлний гийгүүлэгч авианы нөгөө нэг тогтсон байрлал бол үеийн заагт тохиолдох, эс тохиолдох шинж юм. Тодоруулан хэлбэл, нэгэн үгийн дотор хоёр гийгүүлэгч дараалан ороход хүрвэл эхнийх нь өмөнөх үеийг хааж, дараачийнх нь хойдох үеийг нь нээж байдаг. Тийнхүү үе хааж орсон гийгүүлэгч авианы байрлалыг монгол бичигийн зөв бичих дүрэмд *‘дэвэсхэрлэх ёс’* хэмээн нэрлэдэг билээ. Энэ нь үгүүлэгдэх шинжээсээ шалтгаалан ямар гийгүүлэгч ямар гийгүүлэгчтэй үеийн заагт залган орж болох хийгээд эс болохыг нарийвчилан тогтоосон хууль бөгөөд эртнээс нааш хэвшин тогтсон үеийн зааг дахь гийгүүлэгчийн байрлал нь эдүгээ хүртэл тогтвортой хадгалагдсаар иржээ.

Гэтэл кирил бичигийн дүрэмээр үеийн заагт гураваас дөрвөн гийгүүлэгч дараалан орох болсон нь олон зуун жил хэвшин тогтож, уламжилан ирсэн гийгүүлэгч авианы байрлалыг ноцтой зөрчсөн төдийгүй гийгүүлэгч-эгшиг салаавчилан ордог эх хэлний маань эгшиглэнт дуудлага, сонсголт чанар алдагдахад хүрсэн байна. Ийм болсон гол шалтгаан нь авиа зааглаж байгаа богино болон хэт богино эгшигүүдийг гэжж бичих дүрэм зохиосонтой холбоотой. Тийнхүү гийгүүлэгчийн байрлал зөрчигдсөнөөс зөв бичих дүрэм нь хэлнийхээ бодит тогтолцооноос зөрж, үеийн заагт дараалан орсон гийгүүлэгч үсэгүүдийн бичлэгийг зохицуулахын тул *‘эгшигт гийгүүлэгч’*, *‘заримдаг гийгүүлэгч’*, *‘зөөлөрсөн гийгүүлэгч’*, *‘ялгах эгшиг’*, *‘шилжих эгшиг’*, *‘гээгдэх эгшиг’*, *‘гээгдэхгүй эгшиг’* гэх мэт аргацаасан олон дүрэм нэмэж зохиоход хүрсэн байна. Нэмэн зохиосон тэдгээр дүрэмийн зарим нь авианы орчиноосоо шалтгаалан *‘заримдаг гийгүүлэгч нь заримдаа эгшигтэй, заримдаа эгшиггүй бичигдэнэ’*, *‘балархай эгшиг нь заримдаа гээгдэнэ, заримдаа гээгдэхгүй’* гэх мэт тогтворгүй хувилбартай болжээ. Түүнчилэн зарим гийгүүлэгч авианы дараалан орох зүй тогтолыг олж чадаагүйгээс *“С, Х-ийн дараах Т, Ч-гийн дүрэм”* гэх мэт ганцаарчилсан дүрэм бий болсон байна. Энэ мэт тогтолцоогүй, тогтворгүй дүрэм олон байгаа нь ухаарч ойлгоход нэн хэцүү тул арга буюу чээжилэхэд хүрдэг байна.

Кирил бичигийн дүрэмээр үеийн заагт тохиолдох гийгүүлэгчийн байрлалыг зөв тогтоох цорын ганц оновчтой арга нь *‘гээгдэх эгшигийн дүрэм’*-ийг чөлөөлөх явдал юм. Хэрэв *‘гээгдэх эгшигийн дүрэм’*-ийг чөлөөлвөл хоёр гийгүүлэгчийн хооронд орж, тэдгээрийг зааглаж байсан богино эгшигүүд, эцэсийн гийгүүлэгчийн ард орж, өмөнөх гийгүүлэгчээс нь салгаж байсан балархай эгшигүүд дахин гарч ирээд, үеийн зааг дахь гийгүүлэгч авианы байрлалыг зохицуулах үүрэгээ биелүүлэх боломжтой болно.

4.4. Балархай эгшиг буюу “гээгдэх эгшигийн дүрэм”. Залгамал бүтэцтэй монгол хэлний өргөлтгүй үеийн богино эгшиг нь хэл ярианы урасхал дахь авианы орчиноосоо шалтгаалан нэг харьцаанд тод хэлэгдэж, тод сонсогддог, нөгөө харьцаанд сул хэлэгддэг, бүдэг сонсогддог харьцангуй шинжтэй авиа юм. Гэтэл кирил бичигийн зөв бичих дүрэмийг анх боловсруулахдаа *“балархай эгшиг”* буюу үгийн тэргүүн бус үеийн хэт богино эгшигийг гэжж бичихээр журамлажээ. Ер монгол кирил бичигийн зөв бичих дүрэмийн доторхи *“балархай эгшиг”*-ийн тухай асуудал нь өнгөц харвал, зөвхөн өргөлтгүй үеийн богино эгшигийн тухай асуудал мэт боловч хэрэг дээрээ авианы байрлал, үеийн бүтэц хийгээд үгийн бүтэцийг бичигт тэмдэглэхэд шууд болон дам нөлөөлж, уламаар кирил бичигийн зөв бичих дүрэмийн хэл шинжилэлийн үндэслэлийг алдагдуулж, зөв бичих дүрэмийг хэлнийхээ бодит бүтэц, тогтолцооноос хөндийрүүлж байгаа гол зангилаа асуудал юм.

Энэ нь монгол кирил бичигийн зөв бичих дүрэмийг анх боловсруулахдаа авиа зүйн нарийн судалгаан дээр тулгуурлаагүй, зөвхөн энгийн нөхцөлд хэт бүдэг сонсогдох өнгөц шинж дээр тулгуурласан хэрэг байв. Энэ талаар Ц. Дамдинсүрэн бичихдээ: *“тодорхой богино эгшиг балархай болон хувираад улмаар хаягдах тийшээ хандаж яваа тул ... сонсогдохгүй шахам болсон балархай эгшигийг хаях нь зүйтэй байна. ... Бид шинэ үсгийн дүрмийг зохиохдоо балархай эгшигийг дундуур замыг олох хэрэгтэй байлаа. Тэгээд балархай эгшигийг цөмийг бичих*

биш, цөмийг хаях биш, сонсогдох газар нь бичих, сонсогдохгүй газар нь орхихын тул бүх гийгүүлэгчийг эгшигт долоо, заримдаг ес гэж хувааж, балархай эгшигийн дүрмийг зохиосон билээ” (1957: 155) гэжээ. Гэвч тэрбээр эгшигийг гээхгүй бичихийн ач холбогдолын талаар: “Богино эгшигийг гээгдүүлэхгүй болбол үгийн үндэс, дагавар тодорхой болж, хэлний зүйг зааж сургахад дөхөм болох байна. Ийм сайн тал байгаа юм. ... Ер үгийн язгуурыг мэдэхгүй бол ямар ч үгийг зөв бичиж чадахгүй. **Суртал, судал** гэдэг үгийн үндсэнд үйлдэх тийн ялгалын дагаврыг нэмбэл **сурталаар, судалаар** болно. Энэ бол **суртал, судал** гэсэн үгийн үндсийг мэдэхэд амархан байна” (1959: 11) гэх мэтээр дурдсан бий. Үүнээс үзвэл балархай эгшигийг гээж бичихэд үгийн үндэс эвдэгдэхэд хүрч байгааг зөв бичих дүрэмийн үндэсийг боловсруулсан хүн өөрөө олж харсан нь тодорхой байна. Гэвч тэрбээр олон үетэй үгс болон үг бүтээх дагаваруудыг залган бичихэд “сонсдохгүй эгшиг” олоноор бичигдэхэд хүрч байгааг энгийн сонсголоор ажиглаж үзээд балархай эгшигийг гээгдүүлэхээр шийдсэн ажээ. Тийнхүү балархай эгшигүүдийг гээж бичих дүрэм зохиосонтой уялдан элдэв зөрчил гарч ирсэн тул тэдгээрийг зохицуулахын тул ‘эгшигт гийгүүлэгч’, ‘заримдаг эгшиг’, ‘жийрэглэх эгшигийн дүрэм’ зэрэг аргацаах дүрэм зохиоход хүрсэн байна.

Балархай эгшигийн сонсогдох ба эс сонсогдох шинжийн талаар хожим Ш. Лувсанвандан “Балархай эгшиг нь битүү үед огцом, задгай үед хэт огцом, чанга гийгүүлэгчийн завсар буюу дараа, мөн үгийн эцэст дуугүй хэлэгдэх тул чихэнд сонсдохгүй, зөвхөн хий урасан гарна” гэж илүү нарийвчилан тодорхойлсон байна. Түүнчилэн халимаг хэлэнд ч тэргүүн бус үеийн хэт богино эгшигүүд нь авиалбарын үүрэгээ хадгалсаар байгааг туршилт авиа зүйн судалгаагаар нотолсон билээ.

4.4.1. Үеийн бүтэц. Хэл шинжилэлд үеийг ‘цөм’, ‘дагуул’ гэсэн хоёр гол элементээс бүтдэг гэж үздэг. Түүнчилэн америк хэл шинжилэлд үеийг ‘толгой’, ‘хүзүү’, ‘гэдэс’, ‘сүүл’ гэсэн дөрвөн элементээс бүтдэг гэсэн онол ч бас бий. Эртний болон дундад үеийн монгол хэлэнд Э, ЭГ, ГЭ, ГЭГ гэсэн дөрвөн үндэсэн үетэй байсаныг уйгуржин монгол, дөрвөлжин, хитад, араб үсэгээр тэмдэглэсэн монгол хэлний бичигийн дурасхалуудаас тодорхой мэдэж болохоос гадна XIII-XIV зуунаас уламжилалтай монгол хэл зүйн бүтээлүүдэд тогтоосон авианы байрлал нь бичигийн дурасхалуудад туссан авианы тогтолцоотой бүрэн тохирч байна. Түүнчилэн орчин цагийн монгол хэл аялгуунуудад Э, ЭГ, ГЭ, ГЭГ гэсэн дөрвөн үндэсэн үетэй болохыг Д. Амоголонов (1958: 45), П. Ц. Биткеев (1983, 42-47), Ш. Лувсанвандан (1966, 45-46, 1967, 61), Б. Х. Тодаева (1961: 18, 1973, 39), Г. Д. Санжеев (), Д. А. Павлов (1983, 173-187), И. Д. Бураев (1962, 46-48, 1987, 155), Ж. Надмид, Ж. Санжаа (1993, 181), Ж. Цолоо (2008, 207-211) нарын эрдэмтэд тогтоосон билээ. Тэр ч байтугай тэргүүн бус үеийн эгшигүүд нь халх аялгуунаас ч илүү балархайшсан халимаг хэлэнд ч гэсэн дээрхийн адил дөрвөн үндэсэн үе байгааг туршилт авиа зүйн судалгаагаар тогтоосон байдаг (Павлов, 1963: 105, Биткеев, 1975: 126-142). Харин монгол хэлний авианы тогтолцоог нарийвчилан судалсан Б. Я. Владимирцов үгийн эхний дан эгшигээс бүтсэн үеийг бие даасан үед тооцоогүй нь угтаа дан эгшигийн өмөнө ‘үеийн эхлэл’ (on set / clear beginning) хэмээгдэх амисхалын түрэлт байдаг гэсэн онолтой холбоотой буй заа (1929: 417).

Гэтэл одоогийн мөрдөж байгаа кирил бичигийн зөв бичих дүрэмд өмөнө дурдсанчилан өргөлтгүй үеийн бүдэг сонсогдох балархай эгшигүүдийг гээж бичих болсоны уламаас урид өмөнө огт байгаагүй ЭГГ /улс/, ГЭГГ /дарс/, ЭГГГ /элст/, ГЭГГГ/хөрст/ гэсэн бүтэцтэй дөрвөн шинэ үе нэмэгдэн гарч ирэхэд хүрсэн байна. Түүнчилэн одоогоос ерэн жилийн өмөнө боловсруулсан халимаг бичигийн зөв бичих дүрэмд бас дээрхитэй адил дөрөвөөс таван шинэ үе гарч ирэхэд хүрсэн байна. Ийнхүү кирил бичиг дээр тулгуурласан монгол, халимаг бичигт хэд хэдэн шинэ үе тэмдэглэгдэх болсон нь гагцхүү тэргүүн бус үеийн балархай эгшигүүдийг үе бүтээх чадамжгүй гэж үзсэнтэй шууд холбоотой юм. Энэ талаар Ш. Лувсанвандан “Монгол хэлний хэт богино эгшигийг тал бүрээс нь нягтлан судлах явдал бол шинэ үсгийн дүрмийг нарийвчлан боловсруулахад онц холбогдолтой асуудал юм” (1964: 88) хэмээн дурдсан бол Т. А. Бертагаев “халимаг хэлний одоогийн мөрдөж байгаа зөв бичих дүрэмд балархай эгшигүүдийг тэмдэглээгүй орхисон нь уг, морфемын бүтэцийг зөрчсөн тэсвэрлэшигүй алдаа болжээ” (1969: 4) хэмээн тэмдэглэсэн бий.

Эдүгээгээс наяд жилийн өмөнө кирил бичигийн зөв бичих дүрэмийг зохиохдоо авиа зүйн нарийн судалгаан дээр тулгуурлаагүй, сонсхолын баримжааг голлосон учир эх хэлнийхээ авианы байрлал, үеийн бүтэцийг ноцтой зөрчсөн болохыг өмөнө дурдсан билээ. Гэтэл орчин үеийн нарийн багаж төхөөрөмж ашигласан туршилт авиа зүйн сүүлийн үеийн судалгаагаар өргөлтгүй үеийн балархай эгшигүүд нь үе бүтээх чадамжаа алдсан учираас бүрмөсөн гээгдэж, уламаар орчин цагийн монгол хэл нь зургаагаас найман үетэй болсон (Уртнасан нар, 2022: 97-98) гэдэг үр дүн гарсан нь анхаарал татаж байна. Туршилт авиа зүйн судалгаагаар ийм үр дүн гарсаны учир нь хэл ярианы бодит орчиноос нь салгаж авсан саланги үгсийн дуудлагын тогтонги физик шинжийг голлож, хэл зүйн харьцааны хөдлөнг орчин дахь харьцангуй шинжүүдийг орхигдуулсантай холбоотой бололтой. Ийм үр дүн гарсан нь туршилт авиа зүйн солонгон бичлэгийн буруу биш, харин солонгон бичлэгийг үйлдсэн арга зүйтэй холбогдолтой буй заа.

Бодит байдал дээр авч үзвэл монгол хэлний тэргүүн бус үеийн балархай эгшиг нь кирил үсгийн дүрэмээр журамласан шиг, туршилт авиа зүйн судалгаагаар тогтоосон шиг бүрмөсөн гээгдчихсэн биш, харин саланги үгийн түвшинд тодорхой сонсогдохгүй (эс хэлбэржсэн) ч гэсэн хэл зүйн харьцаанд орохдоо огцом сонсогддог харьцангуй шинжтэй авиа юм. Тодоруулбал, балархай эгшиг нь хоёр гийгүүлэгчийн дунд орвол тэдгээрийг зааглаж, гийгүүлэгчийн ард орвол өмөнөх гийгүүлэгчээ салгаж, байр ба харьцаагаараа үе бүтээх чадамжтай авиалбар болдог учир тэдгээр нь бүрмөсөн гээгдээгүй. Гээгдээгүй учираас үеийн зааг дахь гийгүүлэгчийн тогтсон байр ч эвдэгдээгүй, үеийн үндэсэн бүтэц ч өөрчилөгдөөгүй. Гэтэл кирил бичигийн зөв бичих дүрэмд гийгүүлэгч авианы тогтсон байрлал зөрчигдөж, үеийн бүтэц эвдэгдэхэд хүрсэн гол шалтгаан нь гагцхүү “гээгдэх эгшигийн дүрэм”-ийг зохиосон явдал. Тийм учираас кирил бичигийн зөв бичих дүрэмээс “гээгдэх эгшигийн дүрэм”-ийг хасая гэсэн саналыг Ш. Лувсанвандан, Э. Вандуй, Л. Мишиг, Я. Цэвэл, Чингэлтэй, Л. Мишиг, Ж. Надмид, Эрдэнэтогтох нар гаргаж байжээ.

4.4.2. Үгийн бүтэц. Монгол хэлний үгийн бүтэцийг бүтээвэрийн түвшинд задалбал язгуур, үндэс, дагавар, нөхцөл болох бөгөөд тэдгээр нь зөв бичих дүрэмд тогтвортой хадгалагдах ёстой. Гэтэл кирил бичигийн зөв бичих дүрэмд үгийн язгуур – дагавар, үндэс – нөхцөлийн аль аль нь эвдэгдэх болсоныг Ш. Лувсанвандан, А. Лувсандэндэв, Эрдэнэтогтох, Д. Чойжилсүрэн, Я. Цэвэл, Э. Вандуй, Ж. Надмид, Г. Санжеев, Чингэлтэй нар олж ажиглаад “*Үгийн үндэс, дагаварыг тогтвортой болгох нь зүйтэй. Түүний тул гээгдэх эгшигийн дүрэмийг хүчингүй болгох нь зүйтэй*” гэсэн саналыг гаргасан байна. Мөн “*Бүтээвэрүүдийн бүтэцийг сайтар тогтоогоод, түүнийгээ тусхасан тогтвортой бичлэг боловсруулах ёстой*” хэмээсэн оновчтой саналыг Т. Пагба дэвшүүлсэн бий. Үгийн язгуур, үндэс, дагавар, нөхцөлийн бүтэцийг эвдэхгүй бичих нь зөв бичих дүрэмийг тогтвортой, ойлгомжтой болгодог.

4.4.2.1. Язгуурын бүтэц. Ямагт үгийн эхэнд байрлаж, тухайн үгийнхээ утгын цөм болж байдаг язгуур бүтээвэр нь Э-ГЭ, ГЭ-ГЭ, ЭГ-ГЭ, Э-ГЭГ, ГЭ-ГЭГ гэх мэт бүтэцтэй байдаг бөгөөд тэдгээр нь одоогийн зөв бичих дүрэмд эвдэрч, ЭГ, ГЭГ, ЭГГ, ГЭГГ гэсэн бүтэцтэй бичигдэх болсон байна. Язгуур бүтээвэрийн уг бүтэц хийгээд тэдгээрийн эвдэрсэн байдалыг бодит жишээгээр үзүүлбэл:

Э-ГЭ бүтэцтэй үгсийг ЭГ бүтэцтэй болгосон нь

amə	>	ам
emə	>	эм
orə	>	ор
usə	>	ус
ügə	>	үг

ГЭ-ГЭ бүтэцтэй үгсийг ГЭГ бүтэцтэй болгосон нь

bata	>	бат
nerə	>	нэр

tusə	>	тус
türe	>	түр

ЭГ-ГЭ бүтэцтэй үгсийг ЭГГ бүтэцтэй болгосон нь

aġtə	>	агт
erχə	>	эрх
ordə	>	орд
urtə	>	урт

Дээр дурдсан бүтэцтэй үгсийн эцэсийн балархай эгшиг нь саланги үгсийн түвшинд тодорхой сонсогдохгүй байгаа нь үнэн боловч өмөнө дурдсанчилан авиа зааглаж, үе бүтээх үүрэгээ хадгалсаар байгаа төдийгүй хэл зүйн харьцаанд орж, дагавар авч, нөхцөлөөр холбогдохдоо илүү тод сонсогддог, эс сонсогдсон ч араас нь залган орсон гийгүүлэгчийнх нь шинжээр балархай эгшиг байгааг тодорхойлох боломжтой. Түүнчилэн тэргүүн бус, битүү үеийн тодорхой сонсогдож байгаа богино эгшиг ч хүртэл гээгдсэн жишээ цөөнгүй тохиолдож байна.

Э-ГЭГ бүтэцтэй үгсийг ЭГГ бүтэцтэй болгосон нь

arad	>	ард
eles	>	элс
öwös	>	өвс
ömös	>	өмс
ulas	>	улс

ГЭ-ГЭГ бүтэцтэй үгсийг ГЭГГ бүтэцтэй болгосон нь

dawas	>	давс
zürex	>	зүрх
jimes	>	жимс
xumas	>	хумс
dewes	>	дэвс

Тэр ч байтугай ярианы хэлэндээ Э-ГЭГ-ГЭ, ГЭ-ГЭГ-ГЭ гэсэн гурван үеэс бүтэж байгаа *elestə, öwöstə, dawastə, xöröstə* гэх мэт үгсийг зөв бичих дүрэмээр ЭЛСТ, ӨВСТ, ДАВСТ, ХӨРСТ гэсэн ганц үет үг болгон тэмдэглэсэн байна. Бүхэл бүтэн гурван үетэй үгийг ганц үед чихэж багтаасан нь бичигийн хэлийг ярианы хэлнээсээ хэр зэрэг холдуулсаны бодит жишээ болох бус уу. Зуун зууныг дамжин уламжилж ирсэн минга минган үгсийн амийг нь тээж яваа эгшиг авиаг огцом хэлэгдэж, бүдэг дуудагдах шинжээр нь ялгаж, ганц хоёрхон үед багтаахаар амийг нь тасартал атиралдуулан шахаж байгаа байдалыг үнэхээр тэвчимээргүй.

Тийнхүү өргөлтгүй үеийн богино болон балархай эгшигийг гээж бичих болсоноор зөв бичих дүрэмийн бичлэг нь амид хэлнийхээ бодит дуудлагаас ихээхэн зөрөөтэй болоход хүрсэн учир тэдгээрт тохируулсан хувилбар дүрэмүүд зохиосон нь цөөнгүй бөгөөд тэдгээр зохиомол дүрэмийг ухаж ойлгоход нэн бэрх тул чээжилэхээс өөр аргагүйд хүрдэг байна. Бодит байдал нэгэнт ийм болсонтой холбогдуулан Өвөр Монголын эрдэмтэн Эрдэнэтогтох “16-хан үсэгийг зөв бичихийн тул 134 дүрэм чээжилэх шаардлагатай болсон байна” гэж дурдсаныг дахин сануулая.

Жич: Үгийн эцэсийн задгай үеийн хэт балархай эгшиг нь амисхалын сул түрэлт төдий хэлэгдэх боловч авиа салгаж, үе бүтээж, үгийн утга ялгахад оролцож байгаа чадамжийг нь харгалзан тэдгээрийг тусхай үсэгээр тэмдэглэх шаардлагатай гэдэгийг онцлон тэмдэглэе. Тийм учираас дээрхи үгсэд үгийн эцэсийн задгай үеийн *хэт балархай эгшиг* (schwa)-ийг дэлхийн олон хэлэнд нийтлэг хэрэглэдэг *ə*-гээр тэмдэглэв. Цаашид кирил үсэгийн зөв бичих дүрэмд үеийн бүтэцийг зөв тусгахын тул кирил үсэгийн цагаан толгойн бүрэлдэхүүн дэх Ъ болон

‘зартиг’ (apostrophe) /’/ тэмдэгийн аль нэгээр тэмдэглэх боломжтой. Түүгээр ч барахгүй эгшиг зохицолын дагуу АХА, ЭХЭ, ОРДО гэх мэт тэмдэглээд, ярианы дуудлагынхаа дагуу балархай дуудах боломж ч бас бий.

Дангаараа байгаа язгуураас гадна үүсмэл үгийн бүтэцэн дэх анхдагч болон үүсмэл язгуурын бүтэц бас эвдэрсэн жишээ олон байна.

АВАРАЛ (АВАР + /А/Л)	>	АВРАЛ
АРАВУУЛ (АРАВ + УУЛ)	>	АРВУУЛ
БАДАРАЛ (БАДАР + /А/Л)	>	БАДРАЛ
БУТАРАЛ (БУТ + /А/Р + /А/Л)	>	БУТРАЛ
ЗАДАРАЛ (ЗАД + /А/Р + /А/Л)	>	ЗАДРАЛ

4.4.2.2. Үндэсийн бүтэц. Үгийн үндэс нь тухайн үгийнхээ гол утгыг хадгалж, хэл зүйн харьцааны нөхцөлөөр дамжин дараах үгтэй холбогддог билээ. Үгийн үндэсэн дээр харьцааны нөхцөл (нэрийн тийн ялгал, үйл үгийн холбох нөхцөл)-үүдийг залгахад өмөнөх үндэс болон дараах нөхцөлийн бүтэц огт эвдэрэх ёсгүй.

Нэрийн холбох нөхцөлийн өмөнөх үндэсийн бүтэц

БИЧИГИЙН (БИЧ + /И/Г + ИЙН) = БИЧГИЙН
БИЧИГЭЭР (БИЧ + /И/Г + ЭЭР) = БИЧГЭЭР

ҮСЭГИЙН (ҮСЭГ + ИЙН) = ҮСГИЙН
ҮСЭГЭЭР (ҮСЭГ + ЭЭР) = ҮСГЭЭР

ДАРАСНЫ (ДАРАС + /Н/Ы) = ДАРСНЫ
ДАРАСНААС (ДАРАС + /Н/ААС) = ДАРСНААС

Үйлийн холбох нөхцөлийн өмөнөх үндэсийн бүтэц

БИЧСЭНИЙ (БИЧ + СЭН + ИЙ) = БИЧСНИЙ
БИЧСЭНЭЭС (БИЧ + СЭН + ЭЭС) = БИЧСНЭЭС

ГАРДАГИЙН (ГАР + ДАГ + ИЙН) = ГАРДГААС
ГАРДАГААС (ГАР + ДАГ + ААС) = ГАРДГААС

Жич: Дэд үеийн богино эгшигийг гэж бичих нь бага ангийн сургалт болон гадаад хүн монгол хэл сурахад ихээхэн бэрхшээл учруулдаг. Хэлний бүтэц, тогтолцоог мэддэг боловсоролтой хүмүүс НАМАР, ХАВАР гэх мэт олон үг тийн ялгалын нөхцөл авахдаа яагаад уг үндэсээ хадгалахгүй НАМРЫН, ХАВРЫН болж байгаа юм бэ? Ийм дүрэмээ яагаад засахгүй байгаа юм бэ? гэх мэтээр зааж байгаа багшаа хэлэх үггүй болгосон тохиол цөөнгүй бий. Бага ангийн бичхан хүүхэд аман дахь лабартороо ашиглан АЛАС, УЛАС, ХУМАС, ТӨМӨС гэх мэтээр зөв дуудаж, зөв дуудсанынхаа дагуу зөв бичсэн аталаа дүрэмийн дагуу буруу бичсэнд тооцогдоод *онц* дүн авахын оронд *муу* дүн авахад хүрдэг. Ийнхүү эх хэлнийхээ бодит дуудлагын дагуу зөв бичсэн хүүхэд хичээл дээрээ сайшаагдахын оронд олоны өмөнө буруушаагдахад хүрдэг нь сурган хүмүүжил, шударга ёсонд нийцэх үү? Энэ мэтээр “зөв бичих дүрэм” маань “буруу бичих дүрэм” болох нь цөөнгүй.

4.4.2.3. Дагаварын бүтэц. Үгийн язгуур дээр залгаж, шинэ үг бүтээдэг дагаварын бүтэц эвдэрсэн жишээ олон тохиолдож байна.

ДАГАВАРЫН (ДАГА + ВАР + ЫН) = ДАГАВРЫН
БҮТЭЭВЭРИЙН (БҮТ + ЭЭ + ВЭР + ИЙН) = БҮТЭЭВРИЙН

АМЬТАНЫ (АМЬ + ТАН + Ы) = АМЬТНЫ

ЭРХТЭНИЙ (ЭРХ + ТЭН + ИЙ) = ЭРХТНИЙ

АЖИЛЧИНЫ (АЖИЛ + ЧИН + Ы) = АЖИЛЧНЫ
ТАРИАЧИНЫ (ТАРИА + ЧИН + Ы) = ТАРИАЧНЫ

АМСАРЫН (АМ + САР + ЫН) = АМСРЫН
ЗАВСАРЫН (ЗАВ + САР + ЫН) = ЗАВСРЫН

АЙЛЧИЛАЛЫН (АЙЛ + ЧИЛ + /А/Л + ЫН) = АЙЛЧЛАЛЫН
ХАТУУЖИЛЫН (ХАТУУ + Ж + /И/Л + ЫН) = ХАТУУЖЛЫН

Үг бүтээх дагаварын бүтэц эвдэрэхээс гадна адил бүтэцтэй, адил үүрэгтэй нэг дагаварыг дуудлагынх нь хувилбараар хэд хэдэн өөр бүтэцтэй дагавар болгожээ. Тухайлбал, **-la/-le** дагаварыг -Л (тусал-, өргөмжил-, товчил), -ЛА/-ЛЭ || -ЛО/-ЛӨ (баярла-, эзлэ-, орло-, өвлө) гэсэн хоёр өөр хувилбараар, **-lga/-lge** дагаварыг -ЛАГА /-ЛОГО (гарлага, зарлага, бодлого, орлого), -ЛГА/-ЛГО (барилга, тарилга, зорилго, сорилго), ЛГАА/-ЛГЭЭ (баталгаа, тасалгаа, гэрчилгээ, эдэлгээ), -ЛЭГ /-ЛӨГ (үзлэг, эргүүлэг, зөрлөг, мөрдлөг) гэсэн дөрвөн өөр хувилбараар тэмдэглэсэн нь нэг талаар, ярианы хэлнийхээ амид дуудлагыг тусхаж байгаа мэт боловч нөгөө талаар, нэг бүтээврийг хэдэн янзаар бичих болсон нь бүтээвэр зүйн үүднээс, цуваа цагийн хэл шинжилэлийн талаас зохисгүй болсон төдийгүй, кирил бичигийн зөв бичих дүрэмийг будилаантуулсан асуудалын нэг болжээ. Авианы орчиноосоо шалтгаалан нэг дагавар өөр өөрөөр дуудагдах болсон нь үнэн боловч зөв бичих дүрэмд зохистой дундын хувилбарыг олж тогтоох нь зүйтэй.

4.4.2.4. Нөхцөлийн бүтэц. Үгийн үндэсэн дээр залгаж, хэл зүйн харьцаа заадаг нэрийн тийн ялгал, хамаадуулах болон цагийн утга бүхий зарим нөхцөлийн бүтэц эвдэрсэн тохиол цөөнгүй байна.

ГАРДАГААС (ГАР + ДАГ + ААС) = ГАРДГААС
БИЧДЭГЭЭС (БИЧ + ДЭГ + ЭЭС) = БИЧДГЭЭС

ЯВТАЛАА (ЯВ + ТАЛ + АА) = ЯВТЛАА
ИРТЭЛЭЭ (ИР + ТЭЛ + ЭЭ) = ИРТЛЭЭ

АВСАНЫ (АВ + САН + Ы) = АВС + /Н/Ы = АВСНЫ
ШҮҮСЭНИЙ (ШҮҮ + СЭН + ИЙ) = ШҮҮСНИЙ

Дээрхи жишээнд -САН / -СЭН нөхцөлийн бүтэц эвдэрсэн төдийгүй, цагийн утга нь ч бас алдагдаж, АВС, ШҮҮС гэсэн нэрийн үгийн үндэс мэт ойлгогдоход хүрч байна.

5. Судалгааны үр дүн

“Нэг үхэрийн эвэр доргивол минган үхэрийн эвэр доргино” гэгчээр ганцхан гээгдэх эгшигийн дүрэмийн балагаар үе мөч, хаа гуяараа таслагдан тахир татуу болсон минга минган үгийн нурууг нь тэнийлгэж, нугасыг нь амарааж, эрүүл саруул, бүрэн бүтэн болгох ганцхан арга бол гээгдэх эгшигийн дүрэмээс татгалзах явдал юм. Хэрэв тэгэж чадваас түүнийг дагаж гарсан *шилжих эгийг, эгийгт гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгч, дараалсан гийгүүлэгч* зэрэг зохиомол дүрэм аяндаа хэрэглээнээс хасагдаж, үсэгийн дүрэмээ чээжилэх шаардлагагүй, ухаарч ойлгох боломжтой болно. Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэлний хичээлийн сургалтад сөрөгөөр нөлөөлж байгаа нэг гол хүчин зүйл нь үсэгийн дүрэмийн будилаан. 2024 онд ерөнхий боловсролын сургууль төгссөн 5000 гаруй сурагчаас монгол хэл бичигийн шалгалт авахад дөнгөж жараадхан сурагч бүрэн тэнцэж, бусад (бараг 5000) нь хангалтгүй дүн авсан тухай харамсмаар мэдээ хэвлэлд гарсан билээ. Түүнд кирил үсэгийн зөв бичих дүрэмийн өрөөсхөл тал зохих хувийг эзэлсэн гэдэг нь мэдээж.

Даяаршилын эриний шинжилэх ухаан-технологийн дэвшил хөгжил, компьютер техникийн хэрэглээний цар хүрээ үлэмжхэн өргөжиж буй энэ цаг үед кирил үсэгийн бичвэрийг компьютерт хилбар дөхөм таниулах, монгол-кирил-латин бичвэрүүдийн харилцан хөрвөх боломжийг эрээ нэмэгдүүлэх шаардлага өдөрөөс өдөрт нэмэгдсээр байна. Тэдгээр шаардлагыг хангахын тул хэлнийхээ бүтэц, тогтолцоонд тохирсон товч тодорхой дүрэм боловсоруулах нь нэн чухал гэдэгийг өмөнө хэдэнтээ дурдсан билээ.

Хэлэндээ тохирсон боловсоронгуй дүрэмтэй байхын ач холбогдол, үнэ цэнийг дээдсийнхээ уламжилалаас жишээ болгон дурдая. Одоогоос минган жилийн тэртээ бидний өвөг дээдэс уйгурын арван дөрөвхөн үсэгийг авч, эх хэлэндээ тохируулан нэмэж зассаар 123 үе үсэг бүхий боловсоронгуй үсэг бичигтэй болгосон бөгөөд тэрхүү үсэгээр бичиж тэмдэглэсэн хөшөө чулууны бичээс, ном судар олон үлджээ. Эдүгээ бид тэдгээр дурасхалуудаас найман зуун жилийн өмөнөх монгол хэлний авианы бүрэлдэхүүн, тэдгээрийн байрлал, үгийн бүтэц, хэл зүйн харьцааны нөхцөл зэрэг олон шинжийг бүрэн тодорхой мэдэх боломжтой байгаа билээ. Гэтэл кирил бичигийн одоогийн дүрэмээр бичсэн бичвэрээс тэр бүхэнийг бүрэн тогтоож чадах бил үү? Өнөөгийн бидний хэвлэн нийтэлсэн ном зохиол, сонин сэдхүүл, бичиж тэмдэглэсэн аливаа бүхэн ирээдүйд энэ цаг үеийн монгол хэлний бүтэц тогтолцоо, хэл найруулга, яруу уянга, үгсийн баялагийг тусхасан үнэ цэнэтэй бичигийн дурасхал болон үлдэх учиртай. Өөрөөр хэлбэл, эдүгээ цагийн бид бүхэн ирээдүйд үлдэх бичигийн дурасхалаа өдөр бүр бүтээж туурвиж байна гэсэн үг. Бид хойч үедээ үнэн бодьтой, зөв сайн зүйлсийг үлдээх ёстой. Гэтэл бид эх хэлэндээ байхгүй үсэг, шавааралдсан гийгүүлэгч, шахцалдсан үетэйтэйгээ хэдий болтол зууралдах вэ? *“Шинэ үсэгийн дүрэмд битүүлэг зүйл үлэмжхэн бөгөөд түүнийг улам тодорхой болгох нь хэл бичигийн ажилтаны үүрэг”* хэмээн Ц. Дамдинсүрэн багш маань бидэнд захисан биш үү?! Эдүгээ хэл аялгууныхаа бүтэцийг тусхасан зөв бичих дүрэм боловсоруулан хэрэглэх чадамж бидэнд бүрэн бий. Гагцхүү санаачилга л дутагдаж байна.

Миний бие эх хэлнийхээ авиа бүрийн хэлэгдэх шинж, тохиолдох байр, гүйцэдхэх үүрэг, хувьсах зүй тогтолыг олон жил судалж, зүй тогтолыг нь эрхбиш таниж мэдсэн тэр цагаасаа үгийн бүтэцийг хадгалан бичих нь залгамал бүтэцтэй монгол хэлний амин сүнс гэдэгийг сайтар ойлгосон билээ. Тийм ч учираас үгийн язгуур-дагавар, үндэс-нөхцөлийн бүтэцийг эвдэж бичих нь амид амьтаны эрүүл саруул бие эрхтэнийг зэмдэглэн тасалж байгаа мэт төсөөлөгдөх болсоноос үгийн бүтэцийг эвдэж бичихээс ямагт цааргалдаг болсон билээ. Уншигч та бүхэнд толилуулж байгаа энэхүү үгүүлэлээ ч мөн тэр зарчимаараа бичлээ. Энэхүү бичвэр нь үсэгийн дүрэмээ цаашид засан сайжируулах талаар төсөөлөн бодоход дөхөм болох буй заа хэмээн найднам. Хэрэв балархай эгшигийг ямар нэгэн тусхай үсэг тэмдэгтээр тэмдэглэсэн бол үүнээс ч илүү ойлгомжтой болох байсан буй заа. Үүнийг нийтлэх сэдхүүлийн редакци миний энэхүү бичвэрийг өөрчилөлгүй гаргахыг хичээнгүйлэн хүсэе.

6. Дүгнэлт

Эцэст нь тэмдэглэхэд, кирил бичигийн үсэгийн дүрэм хэдийгээр олон будилаантай ч гэсэн тэр бүхэний олонхи нь гагцхүү *“гээгдэх эгшиг”*-ийн дүрэмээс үүдэлтэй, цөөнх нь үсэгийн бүрэлдэхүүнтэй холбоотой юм. Тийм учираас одоогийн мөрдөж байгаа кирил бичигийн зөв бичих дүрэмийг засаж сайжируулахын тул бүх дүрэмийг өөрчилөх шаардлага огт байхгүй, юуны өмөнө *“гээгдэх эгшиг”*-ийн дүрэмийг хүчингүй болгох хэрэгтэй. Хэрэв *“гээгдэх эгшиг”*-ийн дүрэм хүчингүй болбол түүнийг дагалдан гарч ирсэн бусад дүрэмүүд ч аяндаа үйлчилэхгүй болно. Бүр илүү доривтойхон өөрчилөлт хийж, илүү боловсоронгуй үсэгийн дүрэмтэй болоё гэвэл хэрэгцээ багатай зарим үсэгийг хасаж, хэрэгцээтэй цөөн үсэг, тэмдэгт нэмэж авбал бүр ч сайн. Эдүгээ слав болон слав бус хэлтэний хэрэглэж байгаа кирил үсэг нь олон уласын стандартын байгуулгаас баталгаажсан 130 гаруй үсэг бүхий өргөдхөсөн платформтой баялаг сантай болжээ. Тэдгээрээс хэлэндээ тохирсон дуртай үсгээ сонгон авах боломж бидэнд бий. Тэгэж чадвал сурахад амар, сургахад хилбар, цөөн тооны үндэсэн дүрэмтэй болох илүү сайхан боломж бүрдэнэ. Үүнтэй холбогдуулан Ш. Лувсанвандан *“халх аялгууны авианы системийг шинэ үсэгийн дүрэмд хичнээн зөв тусхавал үсэгийн дүрэм ч мөн төчнөөн нарийн системтэй, олон түмний сурч судлахад хялбар дөхөм болно”* ([19645 88-103]

20195 44) гэж тэмдэглэсэнийг онцлон дурдая. Зөв бичих дүрэм шинжилэх ухааны үндэстэй байх ёстой.

Ном зүй

А. Монгол хэлээр:

- Дамдинсүрэн Ц.** (1949). *Монголын шинэ үсгийн товч дүрэм*. Улаанбаатар, 32 тал. // Damdinsüren Ts. *Mongolyn shine üsgiin товч дүрэм*, Ulaanbaatar, 1949, 32 tal. // *A Concise Orthography of Mongolian Cyrillic*, Ulaanbaatar: 1949, 32 pp.
- Дамдинсүрэн Ц.** (1957). Монгол хэл бичгийг сайжруулах тухай, “Монгол хэл бичгийн тухай”, Улаанбаатар, 1957, 138-166. // Damdinsuren Ts. *Mongol khel bichgiig сайжруулах тухай* “Mongol khel bichgiin tukhai”, Ulaanbaatar. 1957, 138-166 // *The Development of the Mongolian Philology, “On the Mongolian Philology”*, 1957, 138-166
- Лувсанвандан Ш.** (1964). Монгол хэлний халх аялгууны балархай эгшгийн тухай асуудалд, *Шинжлэх ухааны академийн мэдээ*, 2, 1964, 88-103 // Luvsanvandan Sh. *Mongol khelnii khalkh ayalguuny balarkhai egšgiin tukhai asuudald*, *Shinjilekh ukhaany akademiin medee*, 2, 1964, 88-103 // *On Some Problems on the Reduced Vowels in Khalkha Dialect of Mongolian, Bulletin of the Mongolian Academy of Sciences*, 2, 1964, 88-103
- Лувсанвандан Ш.** /ерөнхий редактор/ (1966). *Орчин цагийн монгол хэлний зүй*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966, 344 тал. // Luvsanvandan Sh. *Orchin tsagiin mongol khelnii züi*, Ulaanbaatar: Ulsiin khlevleliin khereg erkhekh khoroо. 1966, 344 tal. // *Modern Mongolian Grammar*, Ulaanbaatar: State Committee for Publishing Affairs, 1966, 344 pp.
- Лувсанвандан Ш.** (1967). *Орчин цагийн монгол хэлний зүй*: I дэвтэр. *Авиа, авиалбар хоёр*, Улаанбаатар: ШУАХ, 1967, 166 тал. // Luvsanvandan Sh. *Orchin tsagiin mongol khelnii züi*: I devter. *Avia, avialbar khoyor*. Ulaanbaatar: ShUAKh, 1967, 166 // *Modern Mongolian Grammar. I. Sound and Phonemes*, Ulaanbaatar: Press of Mongolian Academy of Sciences, 166 pp.
- Лувсандэндэв А.** /редактор/ (1959). *Монгол хэл бичгийн зарим асуудал*, Улаанбаатар, Эрдэм шинжилгээний хэвлэлийн газар, 1959, 76 тал. // Luvsandendev A. *Mongol khel bichgiin зарим асуудал*, Ulaanbaatar: Erdem shinjilgeenii khvleliin gazar 76 tal. // *On Some Problems of Mongolian Philology*, Ulaanbaatar: Publishing House of Research Works, 1959, 76 pp.
- Надмид Ж. Санжаа, Ж.** (1993). Орчин цагийн монгол хэлний авиа зүй. Улаанбаатар: 379 тал. // Nadmid J, Sanjaa J. *Orchin tsagiin mongol khelnii avia züi*, Ulaanbaatar, 379 tal. // *The Phonetics of Modern Mongolian*, Ulaanbaatar. 379 pp.
- Ринчен Б.** (1964). *Зөв бичих дүрэм шинжлэх ухааны үндэстэй байх ёстой*, “Үнэн” сонин. Улаанбаатар, 1964. 7. 2 // Rinchen, B. *Zöv bichikh дүрэм шинжлэх ухааны үндэстэй байх ёстой*, “Ünen” sonin 1964. 7. 2 // *The Orthography Must be Based on Scientific Principle*, Newspaper “Ünen”, Ulaanbaatar: 1964.7. 2
- Уртнасан Д. Батдорж Ц. Батхишиг С.** (2002). *Авиа зүй*. {= *Монгол хэл судлал*. VIII}. МУИС. Монгол судлалын Хүрээлэн. Улаанбаатар: 2022, 207 тал. // Urtnasan D. Batdorj Ts. *Batkhisig S. Avia züi* {= *Mongol khel судлал VIII*}, MUIS. *Mongol судлалын khüreelen*, Ulaanbaatar, 207 tal. // *Phonetics and Phonology* {= *Mongolian Language Studies*. VIII}, Institute for Mongolian Studies. Ulaanbaatar: 2002, 207 pp.
- Цолоо Ж.** (2008). Орчин цагийн монгол хэлний авиа зүй. Улаанбаатар. 418 тал. // Tsoloo J. *Orchin tsagiin mongol khelnii avia züi*, Ulaanbaatar, 418 tal. // *The Phonetics of Modern Mongolian*, Ulaanbaatar. 418 pp.

Б. Гадаад хэлээр:

- Амоголонов Д.** (1958). *Современный бурятский язык*. Улан-Удэ: Бурятское книжное издательство, 337 стр. // Amogolonov D. *Sovremennyi buryatskii yazyk*, Ulan-Üde: Buryatskoe knijnое izdatel'stvo, 337 str. // *Modern Buryat Language*, Ulan-Ude: Buriat Publisching House, 1958, 337 pp.
- Биткеев П. Ц.** (1969). *Проблемы графики и орфографии современного калмыцкого языка*. Элиста: Калмыцкое книжное издательство, 439 стр. // Bitkeev P. C. *Problemy grafiki i orfografiï sovremennogo kalmyckogo yazyka*, Elista: Kalmyckoe knijnое izdatel'stvo, 439 str. // *Some Problems of Graphics and Orthography of the Modern Kalmyk*, Elista: Kalmyk State Publishing House, 439 pp.
- Биткеев П. Ц.** (1975). *Проблемы фонетики калмыцкого языка: Квантитативные и качественные изменения гласных*. Элиста: Калмыцкое книжное издательство, 1975, 163 стр. // Bitkeyev P. Ts. *Problemy fonetiki kalmyckogo yazyka: Kvantitativnye i kvalitativnye izmeneniya glasnykh*, Elista,

- Kalmyckoe knijnnoe izdatel'stvo, 1975, 163 str. // *Problems of Kalmyk Phonetics: Quantitative and Qualitative Changes of Vowels*, Elista: Kalmyk Publishing House, 1975, 163 pp.
- Биткеев П. Ц, Дамбинова В. Д, Дораева Р. П, Каляев А. Л, Манджикова Б. Б, Монраев М. У, Очир-Гаряев В. Э, Павлов Д. А, Пюрбеев Г. У, Убушаев Н. Н.** (1983). *Грамматика калмыцкого языка*. (1983). Элиста: Калмыцкое книжное издательство, 336 стр. // Bitkeev P. C, Dambinova V. D, Kalyaev A. L, и др. *Grammatika kalmyckogo yazyka*, Elista: Kalmyckoe knijnnoe izdatel'stvo, 336 str. // *Grammar of Kalmyk Language*, Elista: Kalmyk Publishing House, 1983, 336 pp.
- Будагов Р. А.** (1971). *Язык, история и современность*. Москва: Изд-во МГУ. 299 стр. // Budagov R. A. *Yazyk, istoriya i sovremennost'*. Moskva: izdatel'stvo MGU, 299 str. // *Language, History and the Present Time*, Moskow: Moscow State University Press, 1971, 299 pp.
- Бураев И. Д.** (1987). *Становление звукового строя бурятского языка*. Новосибирск. 184 стр. // Burayev I. D. *Stanovlenie zvukogo stroya buryatskogo yazyka*, Novosibirsk. 184 str. // *Formation of Phonetic System of the Buryat Language*, Novosibirsk. 184 pp.
- Владимирцов Б. Я.** (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*. Ленинград: 436 стр. // Vladimirtsov B. Ya. *Sravnitel'naya grammatika mongol'skogo pis'mennogo yazyka i chalchaskogo narechiya*, Leningrad, 1929, 436 str. // *Comparative Grammar of the Mongolian Written Language and the Khalkha Dialect*, Leningrad. 1929, 436 pp.
- Павлов Д. А.** (1963). Состав и классификация фонем калмыцкого языка. Элиста: Калмгосиздат. 107 стр. // Pavlov D. A. *Sostav i klassifikaciya fonem kalmyckogo yazyka*, Elista: Kalmgosizdat. 107 str. // *Components and Classifications of the Kalmyk Phonemes*, Elista: Kalmyk State Publishing House, 1963, 107 pp.
- Павлов Д. А.** (1983). Фонетика современного калмыцкого языка. Элиста: Калмгосиздат. 208 стр. // Pavlov, D. A. *Fonetika sovremennogo kalmyckogo yazyka*, Elista: Kalmgosizdat. 208 str. // *Phonetics of Modern Kalmyk*, Elista: State Publishing House, 1983, 208 pp.
- Санжеев Г. Д, Бертагаев Т. А, Цыдендамбаев Ц. Б.** /Ред. коллегия/ (1962) *Грамматика бурятского языка. Фонетика и морфология*. Москва, 340 стр. // Sanžeev G. D, Bertagaev T. G. Cydendambaev C. B. /redakcionnaya kollegiya/. *Grammatika buryatskogo yazyka. Fonetika i morfologiya*, Moskva, 340 str. // *The Buriat Grammar. Phonetics and Morphology*, Moskow: 1971, 340 pp.
- Тодаева Б. Х.** (1961). *Дунсянский язык*. Москва: Издательство Восточной Литературы, 147 стр. // Todayeva B. Kh. *Dunsyanskii yazyk*, Moskva: Izdatel'stvo Vostočnoi Literatury 147 str. // *Dongxiang Language*, Moskow: Oriental Studies Press, 147 pp.
- Тодаева Б. Х.** (1973). *Монгорский язык. Исследование, тексты, словарь*, Москва: "Наука", 389 стр. // Todayeva, B. Kh. *Mongorskii yazyk: Issledovanie, teksty, slovar'*, Moskva; Nauka, 389 str. // *Monguor Language*, Moskow: "Nauka", 389 pp.